| 122 | Алсын хараа-2050-ийн 5.2.4, МУХҮЧ-5.1.3, ЗГҮАХ-4.2.10, АХҮЧ-5.1.1, 5.2.1 АЗДҮАХ- | Төрийн зарим чиг үүрэг /хөндлөнгийн хяналт тавих, төсөл хэрэгжүүлэх, сургалт явуулах, санал асуулга явуулах гэх мэт/-ийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, иргэн, ТББ-ын оролцоог нэмэгдүүлнэ. | | Аймгийн ЗДТГ | ОНТ | 1,909.6 | 42 төсөл 168,2 хүртэл | Төр, ТББ-ын хамтын ажиллагаа сайжирсан байна. | 100.0 | 1,909.6 | 2023 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 1,044.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд дэд бүтэц, нийгмийн чиглэлийн 71 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 1,315.7 сая төгрөгөөр зарцуулж байна.<br>**Үр дүн:** Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 115 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 1,909.6 сая төгрөг зарцуулж байна. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.1.2.3 | | | | | | | | | | | |
| | **3.1.3. Төрийн албан хаагчдыг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран сурч хөгжих орчныг бүрдүүлж, мэдлэг, чадварыг дээшлүүлэн, тогтвор суурьшилтай ажиллуулна.** | | | | | | | | | | | |
| 123 | Алсын хараа-2050-ийн 5.4.4, МУХҮЧ-5.4.2, 5.4.4 ЗГҮАХ-4.2.6, АХҮЧ-5.3.1, 5.3.2, 5.3.3, 5..3.4 АЗДҮАХ-3.1.3.5. | Төрийн албаны тухай хуульд заасан чадахуйн зарчимд үндэслэн төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах, томилох, албан тушаал дэвшүүлэх зарчмыг хэрэгжүүлнэ. | | Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ, Төрийн байгууллага | - | | Нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн удирдах албан тушаалын 8, гүйцэтгэх албан тушаалын 62, туслах албан тушаалын 8 сул орон тооны судалгаа байна. | Төрийн албаны тусгай шалгалтын дүн | - | | Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь Салбар зөвлөлөөс 2023 онд Төрийн албаны тусгай шалгалтыг 10 удаа зохион байгуулж 96 сул орон тоог нээлттэй зарлаж Төрийн албаны тухай хуульд заасан чадахуйн зарчимд үндэслэн төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагч болон төрийн албаны нөөцөд байгаа 292 иргэнээс албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагын дагуу сонгон шалгаруулж 134 иргэнийг нэр дэвшүүлж, 150 сул орон тоо нөхсөн байна. Төрийн жинхэнэ албанд орох хүсэлтэй иргэнийг сонгон шалгаруулж, төрийн албан хаагчийн нөөц бүрдүүлэх зорилгоор төрийн албаны ерөнхий шалгалтыг улирал тутам зохион байгуулж 2023 онд 388 иргэд шалгалт өгөхөөр бүртгүүлж үүнээс 253 иргэн шалгалт өгч 110 иргэн шалгалтад тэнцэж төрийн албан хаагч нөөцөд бүртгүүлсэн байна.<br>**Үр дүн:** Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн дагуу чадахуйн зарчимд үндэслэн 150 сул орон тоог нөхсөн байна. | 100% |
| 124 | Алсын хараа-2050-ийн 5.4.4, МУХҮЧ-5.4.2, 5.4.4 ЗГҮАХ-4.2.6, АХҮЧ-5.3.1, 5.3.2, 5.3.3, 5..3.4 АЗДҮАХ-3.1.3.6. | Салбар зөвлөлийн харьяа 23 Ёс зүйн зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангах, Ёс зүйн зөвлөлийн дүрэм боловсруулж, мөрдүүлнэ. | | Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ, Төрийн байгууллага | - | | Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн харьяа 23 Ёс зүйн зөвлөл, 76 хорооны гишүүд үйл ажиллагаа явуулж байна. | 23 ёс зүйн зөвлөл | - | | Улсын Их Хурлын сахилга хариуцлагын байнгын хороо, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төслийг хэлэлцүүлэн, "Төрийн албаны шинэтгэл, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем, танилцуулга сургалт, төрийн байгууллагын Ёс зүйн хорооны 100 гишүүнийг чадавхжуулах сургалтыг 2023 оны 3 дугаар сард зохион байгуулж, төрийн байгууллагын 400 гаруй албан хаагчдыг оролцуулан сургалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Төрийн албаны хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад дээрх хуулийг төрийн албан хаагчдад сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах чиглэлийг өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Салбар зөвлөлөөс шинээр батлагдсан хууль тогтоомжийг төрийн албан хаагчдад сурталчлах, сургалт зохион байгуулах чиг үүргийн хүрээнд 2023 оны 10 дугаар сард "Төрийн албан хаагчийн ёс зүй, гүйцэтгэлийн удирдлага" сэдэвт сургалтыг 26 төрийн байгууллагын 878 төрийн албан хаагчийг хамруулан сургалт зохион байгууллаа.<br>**Үр дүн:** Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан төрийн байгууллагын ёс зүйн хорооны ажиллах дүрэм, журам батлагдаж, хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж 1200 гаруй төрийн албан хаагчийн хамруулаа. | 100% |
| 125 | ЗГҮАХ-4.5, АХҮЧ-5.2.2, АЗДҮАХ 3.1.4.1. | Шууд болон ах дүү хотуудын уламжлалт найрсаг харилцааг өргөжүүлнэ. | | Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ | - | | ОХУ-ын Эрхүү мужийн Братск хот, Испанийн Вант улсын Астуриас муж, БНУнгар улсын Капошвар хоттой гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлсэн. | Хоёроос доошгүй гадаадын шинэ муж, хотуудтай харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | - | | 2023 онд Канад, Бүгд Найрамдах Турк улс, Япон, Австрали, Унгар зэрэг 5 улсын элчин сайдуудыг хүлээн авч уулзсан.<br>-ОУБ-НК групп, Энх тайвны корпус, НҮБ-ийн Хүн амын сан, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг, Дэлхийн олон улсын Энэрэлийн байгууллага, Найрамдал төслийн санхүүжүүлэгч ЕХ-ны суурин төлөөлөгч, НҮБ-ийн хүүхдийн сан зэрэг 9 олон улсын байгууллагтай хамтын ажиллагаа өрнүүлсэн.<br>1.Италийн Бэлфил ХХК болон Ханбогд Кашмер ХХК-тай ноолуурын үйлдвэр байгуулах гурвалсан санамж бичиг,<br>2.БНСУ-ын Кёнги аймагтай ах дүү хотын санамж бичгийг шинэчлэн байгуулсан<br>3.БНСУ-ын Чөрвон сум, Дархан-Уул аймгийн Хонгор сумтай хамтын ажиллагааны санамж бичиг<br>4.БНСУ-ын Сөүл хотын Ихау эмэгтэйчүүдийн сургуулийн эмнэлэгтэй эмнэлгийн салбарт хамтран ажиллах санамж бичиг<br>5. ОХУ-ын Эрхүү мужийн Братск хоттой хоёр хотын хүүхдүүдийг хүүхдийн зусланд солилцоогоор амраах харилцан ойлголцлын гэрээ байгуулснаар энэ жил нийт 3 хамтын ажиллагааны болон ах дүү хотын 1 санамж бичиг, 1 гэрээ байгуулсан. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 126 | ЗГҮАХ-4.5, АХҮЧ-5.2.2, АЗДҮАХ 3.1.4.2. | Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг гадаадын төсөл хөтөлбөрт хамруулах, байгууллагуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ. | | Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ<br><br>ТЗУХ | - | | Орон нутгийн 39 үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлсэн | 10 хүртэл орон нутгийн ААНБ | - | | 2023 онд Найрамдал төслийн хүрээнд Австри улсын "ЮНИ КРЕДИТ" банкны санхүүжилтээр эргэн төлөх нөхцөлгүйгээр 7,5 сая еврогийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн.<br>Дархан хотын бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдхүүнийг сурталчилан танилцуулахаар Эрхүү мужийн Братск хотын "Эдийн засгийн IV дүгээр форум"-д МҮХАҮТ-ын Дархан салбар танхимын гишүүн байгууллагууд буюу Дархан хотын Дархан савхи, Дархан нэхий, Цайны их зам, Дархан ширэн урлал, Амина Х.Х, Гоёл кашмер, Таймлесс зэрэг нийт 7 аж ахуйн нэгжүүд оролцсон.<br>Найрамдал төслийн хүрээнд Дархан-Уул аймгийн жижиг дунд бизнесийг дэмжих зорилгоор нийт 6 гарааны бизнес, мөн эмнэлэгийн үйлчилгээг цахимжуулах, ТАХ-ыг цахимжуулах сургалт, дахин төлөвлөлт зэрэг нийт 5 зорилтот төсөл болон бусад төсөл хөтөлбөрүүдэд нийт 640 сая төгрөгийн санхүүжилт олгосон.<br>**Үр дүн:** Найрамдал төслийн хүрээнд Дархан-Уул аймгийн нийт 16 аж ахуйн нэгжид 640 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | 100% |
| | **3.2. УХААЛАГ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | | | | | | | | |
| | ***3.2.1. Цахим технологид суурилсан төрийн үйлчилгээг нэмэгдүүлж, шуурхай хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.*** | | | | | | | | | | | |
| 127 | ЗГҮАХ-4.1, 4.1.1 АХҮЧ-5.1.1, АЗДҮАХ 3.2.1.1. | "Цахим Дархан" төсөл батлагдсан. | | Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ, "Мэдээлэл технологийн алба" ОНӨААТҮГ | ОНТ | | "Ухаалаг Дархан" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж орон нутагт төрийн үйлчилгээг цахимжуулах, дижитал шилжилтийн платформуудыг нэвтрүүлсэн. | "Ухаалаг Дархан" төслийг хэрэгжүүлнэ. | 60.0 | | Төрийн цахим үйлчилгээний төв И-Монголиа төвөөс нийт 61 байгууллагын 923 төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Үүнд олон шаталт үйлчилгээ-801, лавлагаа-121, шинээр шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт, Эрүүл мэндийн байгууллагаас цаг авах, эмнэлгийн магадлагаа, Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, шинжилгээний хариу, ХХҮГ-аас хүүхэд асарсны тэтгэмж, авах хүсэлт, мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ, НД-аас ажилгүйдлийн, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт, сайн дураар даатгуулах хүсэлт зэрэг үйлчилгээг үзүүлж байгаа бол Дархан-Уул аймгаас Стандарт хэмжил зүйн төв, Ус суваг, ЭМГ, Авто тээврийн төв, УБГ, БОАЖГ зэрэг байгууллагууд зарим үйлчилгээний тусгай зөвшөөрлийг цаг алдалгүй авах болсон. Тухайлбал Дархан ус суваг ХК техникийн нөхцөл олгох хүсэлт, Стандарт хэмжил зүйн газар тохирлын үнэлгээ хийх хүсэлт зэрэг үйлчилгээг үзүүлдэг болсон.<br>**Үр дүн:** Нийт 61 байгууллагын 923 төрлийн үйлчилгээг үзүүлж байна.<br>"И-ДАРХАН цахим платформ"-ын вэб сайт болон гар утасны аппликейшныг хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>Ашиглаж буй хэрэглэгчийн тоо 503, төрийн болон ОНӨГ зэрэг 46 байгууллагыг системд бүртгэж админ нарт практик сургалт орсон.<br>И-Дархан аппликэйшн, Төрийн байгууллагуудын үйлчилгээнд иргэд санал гомдол явуулдаг систем хэрэгжиж эхэлснээр нийт 99 санал гомдол хүлээн авч шийдсэн. | 100% |
| 128 | ЗГҮАХ-4.1, 4.1.1 АХҮЧ-5.1.1, АЗДҮАХ 3.2.1.3. | Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцооны системийн ашиглалтын чанарыг сайжруулна. | | "Мэдээлэл технологийн алба" ОНӨААТҮГ | ОНТ | | Төрийн дотоод удирдлагын мэдээлэл солилцооны системийн төрийн 106 байгууллагын 725 хэрэглэгч хэрэглэж байна. | Хэрэглээг идэвхжүүлэх сургалт модулиудыг авч үндсэн хэрэглэгчийн тоог нэмэгдүүлнэ. | 7.0 | | 2023 онд Эйбл систем нь 124 байгууллагын нийт 3591 хэрэглэгч бүртгэгдсэн ба able програмын ашиглалтыг хангаж, 341 өргөдөл гомдлыг хяналтад авч, шийдвэрлэсэн.<br>"И-ДАРХАН цахим платформ"-ын вэб сайт болон гар утасны аппликейшныг хэрэглээнд нэвтүүлсэн.<br>Ашиглаж буй хэрэглэгчийн тоо 503, төрийн болон ОНӨГ зэрэг 46 байгууллагыг системд бүртгэж админ нарт практик сургалт орсон.<br>И-Дархан аппликэйшн, Төрийн байгууллагуудын үйлчилгээнд иргэд санал гомдол явуулдаг систем хэрэгжиж эхэлснээр нийт 99 санал гомдол хүлээн авч шийдсэн.<br>**Үр дүн:** Эйбл систем нь 124 байгууллагын нийт 3591 хэрэглэгч бүртгэлтэй байна. Able програмын ашиглалтыг хангаж, нийт 712 өргөдөл гомдлыг хяналтад авч, шийдвэрлэснээс гадна Өргөдөл, гомдлыг И-Дархан, Эрсдэл аппликейшнаар бүртгэлжүүлж, цахимаар хүлээн авч нийт 471 санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэж ажилласан. | 100% |
| | **3.3. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО** | | | | | | | | | | | |
| | ***3.3.1. Аймгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ.*** | | | | | | | | | | | |
| 129 | "Алсын хараа-2050" зорилт | Гамшгийн эрсдэлийг | | Онцгой | ОНТ | | Гамшгийн | Төлөвлөгөөг | ҮА | | Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2023 оны | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 7.3, 1 үе шат 2021-2030 АХҮЧ-7.1.6 АЗДҮАХ-3.3.1.1. | бүүрүүлах орон нутгийн зөвлөлийн гишүүдийг шинэчлэн байгуулж, жил бүр төлөвлөгөө батлуулна. | | байдлын газар | | 100.0 | эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг шинэчлэн байгуулсан. | дүгнэж, зөвлөлийн хуралдааныг 1-ээс доошгүй удаа хийнэ. | зардал | 100.0 | үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, тайлангийн биелэлтийг хангаж ажилласан ба тухайн онд 100 сая төгрөгийг захиран зарцуулан ажилласан байна. | 100% |
| 130 | "Алсын хараа-2050" зорилт 7.3, 1 үе шат 2021-2030 МУХТЖҮЧ-6.4.3, ЗГҮАХ-4.3.11 АХҮЧ-7.1.6 ЗДҮАХ-3.3.1.2, 4.3.11 | Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг бэхжүүлэх хүрээнд аврах ажиллагаа явуулах нөхцөлийг сайжруулах | | Онцгой байдлын газар | Гадаад зээл тусламж | 591.2 | БНСУ-ын олон улсын галын академид 15 алба хаагч хамрагдсан. Аврах ажиллагааны багаж техник хэрэгсэл 65 хувьтай байна. | Усноос эрэн хайх аврах ажиллагааны техник, багаж зэвсэглэмжийг 80 хувьд хүргэнэ. | 500.0 | 591.2 | 2023 оны 10-р сарын 02-нд Турк улсад зохион байгуулагдсан Найрамдал төслийн хүрээнд европын орнуудтай хийх уулзалтад Дархан-Уул аймгийн Гамшгийн нөхцөл байдал хариу арга хэмжээ, удирдлага зохион байгуулалт сэдвээр илтгэлд 1 алба хаагч оролцсон. МУЗГ-ын тогтоолоор 540,2 сая төгрөгийн үнэ бүхий 3 нэгж техник хүлээн авч техник бэлэн байдлыг дээшлүүлсэн. /ковш-50-1ш, ниссан патрол-1ш, ланд круизер-78-1ш/ Мөн ОБГ-ын өргөтгөлийн барилгын 2 дугаар давхарт байрлах "Иргэний сургалт арга зүйн танхим"-ыг байгуулах төслийн хүрээнд Австрали улсын тусламжаар 51 сая төгрөгийн үнэ бүхий ЛЕД дэлгэц, дагалдах хэрэгслийг хүлээн авсан ба уг танхимыг тохижуулахад шаардлагатай үлдэгдэл техник хэрэгслийг БНСУ-ын Кёнги аймгийн тусламжаар шийдвэрлүүлэхээр 25 сая төгрөгийн төслийг хүргүүлээд байна. | 70% |
| 131 | "Алсын хараа-2050" зорилт 7.3, 1 үе шат 2021-2030 АХҮЧ-7.1.6 АЗДҮАХ-3.3.1.4. | Дархан сумын эргэн тойронд аянга зайлуулах хамгаалалтын системийн тоог жилд нэгээр нэмж байгуулна | | Онцгой байдлын газар | ОНТ | | Дархан сумын 9, 15 дугаар багийн нутаг дэвсгэрт 2 ширхэг босоо аянга хүлээн авагч суурилуулсан | 1-ээс доошгүй аянга зайлуулагч шинээр нэмэгдүүлнэ. | 15.0 | 0.0 | Дархан сумын эргэн тойронд аянга зайлуулах хамгаалалтын систем нь 2019 онд Дархан сумын 9, 15-р багт хийгдсэн байна. 2021-2023 онд дахин аянга зайлуулах хамгаалалтын системийн хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй тул хийгдээгүй. | 0% |
| | ***3.3.2.Дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг дээшлүүлнэ*** | | | | | | | | | | | |
| 132 | МУХҮЧ-7.1.2 ЗГҮАХ-4.6.3, 4.6.8 АЗДҮАХ-3.3.2.2. | Аймгийн дайчилгаа удирдах бүлэгт томилгооны дагуу үүрэг гүйцэтгэх үндсэн үүргийн талаар сургалт дадлага зохион байгуулж, шаардлагатай материал, хувцас хэрэглэлээр хангана. | | Цэргийн штаб | ОНТ | | Аймгийн Засаг даргын захирамжаар цугларах, шилжүүлэх байрыг томилгоожуулсан. | Томилгоот байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнууд томилгоожиж, үүрэг гүйцэтгэх боломж хангагдана. | 6.0 | 0.0 | **1.Батлан хамгаалах газар:** Дархан-Уул аймгийн Засаг дарга, Батлан хамгаалах газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн МН/01 дүгээр захирамжаар "Дархан-Уул аймгийн батлан хамгаалах газар"-ын бүрэлдэхүүнийг томилох тухай захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Батлан хамгаалах газарт нийт 27 албан тушаалтанг томилгоожуулан тэдгээрийн бэлэн байдлыг хангах үүднээс зарлан мэдээлэл явуулах бүдүүвчийг боловсруулан харилцан ажиллагааг зохион байгуулан тодотгол хийж нууцын баталгааг гаргуулсан. **2.Цугларах шилжүүлэх байр:** Дархан-Уул аймгийн Засаг дарга, Батлан хамгаалах газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн МН/02 дугаар захирамжаар "Дархан-Уул аймгийн цугларах, шилжүүлэх байр"-ын бүрэлдэхүүнийг томилох тухай захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Дархан-уул аймгийн цугларах байранд нийт 30 албан тушаалтан, шилжүүлэх байранд нийт 20 албан тушаалтан томилож тэдгээрийн бэлэн байдлыг хангах үүднээс зарлан мэдээлэл явуулах бүдүүвчийг боловсруулан харилцан ажиллагааг зохион байгуулан тодотгол хийж цугларах байрын бүрэлдэхүүнд 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр сургалт явуулж нууцын баталгааг гаргуулан ажил үүргийн хуваарийг танилцуулсан. | 100% |
| 133 | МУХҮЧ-7.1.2 ЗГҮАХ-4.6.3, 4.6.8 АЗДҮАХ-3.3.2.3. | Хээрийн сургалтын төвд хичээлийн байр, ерөнхий цэргийн саад, буудлагын талбайг тохижуулж, тоноглоно. | | Цэргийн штаб | ОНТ | 20.0 | Сургалтын төвд 50 сая төгрөгний үнэ бүхий 3 ш амрах байрыг байрлуулсан. | Сургалтын материаллаг бааз бэхжинэ | 50.0 | 20.0 | Сургалт явуулах орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд хээрийн сургалтын төвийн байрлалд явган хүний зам, жагсаалын талбайн индэр, гэрлийн шон, орон нутгийн хөрөнгө оруултаар 20 сая төгрөгний үнэ бүхий 40 хүний багтаамжтай 2 ширхэг сэндвич байрыг байрлуулсан. | 100% |
| | **3.4. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | |
| | ***3.4.1. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.*** | | | | | | | | | | | |
| 134 | МУХТЖҮЧ-5.6.2 ЗГҮАХ-4.2.1 | | | | | | 2018-2020 оны | Арга хэмжээний | 5.0 | 0.0 | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийн төсөл"-д санал авах тухай 01/3476 дугаартай албан бичгийн хариуд 4 санал хүргүүлснээс 1 санал | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | АХҮЧ-5.4.2 АЗДҮАХ-3.4.1.3. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ. | | ХЭЗХ | ОНТ | | дундаж- 91.4% | хэрэгжилтийг 94.4 хувьд хүргэнэ. | | | тусгагдсан.<br>2023.06.30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр" батлагдсан. 2023.12.04-ны өдрийн 08/19784 дугаартай албан бичгээр үндэсний хөтөлбөрт заагдсан зорилго, зорилтуудыг байгууллагынхаа 2024 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх чиглэл өгсний дагуу аймгийн 2024 оны "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-д тусгахаар төлөвлөгөө боловсруулж байна.<br>Аймгийн хэмжээнд авлигын эсрэг, урьдчилан сэргийлэх чиглэлээр 9 удаагийн сургалтад 466 албан хаагчийг хамруулж, видео шторкыг орон нутгийн телевизээр 3400 удаагийн давтамжтайгаар цацаж, цахим сүлжээнд постер, шторк, нийтлэлүүд 64300 орчим иргэнд хүрсэн. Авлигын эсрэг олон улсын өдрөөр " Үл тэвчье, үл эвлэрье" өдөрлөг зохион байгуулж үүний хүрээнд 3 төрлийн уралдаан зарлаж нийт 95 бүтээл ирснээс 12 шагнал байр, 4 гарын бэлэг гардуулсан. Уралдаанд шалгарсан шилдэг видео контентыг олон нийтэд түгээж байна.<br>Нийгмийн салбарын 8 байгууллага дунд "Дэвжээ" тэмцээн зохион байгуулж төрийн 3 байгууллагатай хамтран видео контент бүтээн олон нийтэд авлигыг үл тэвчих үзлийг төрийн байгууллагын оролцоотойгоор түгээн дэлгэрүүлж байна. "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд "НЭГДЬЕ" аяныг зохион байгуулан төв зам дагуу 4 том анонс байрлуулж, 100ш зурагт хуудас, 10ш стикерийг багийн төвийн байр, автобусны буудал, томоохон худалдааны төвүүдэд байрлуулж, орон нутгийн телевизээр шторкыг 3400 удаагийн давтамжтайгаар цацаж, цахим сүлжээнд постер, шторк, нийтлэлүүдийг 64300 иргэнд хүргэсэн.<br>**Үр дүн:** "Шүүр ажиллагаа"-ны хүрээнд 11 чиглэлээр хяналт, шалгалт хийж 52 зөрчлийг илрүүлж, ХАСУМ-г АТГ-т хянуулаагүй томилогдсон, ХАСХОМ-гийг мэдүүлэх үүргээ биелүүлээгүй 6 зөрчлийг арилгуулаа. | |
| 135 | | Соён гэгээрүүлж, урьдчилан сэргийлнэ. | | ХЭЗХ | ОНТ | 0.0 | 338 хүнд сургалт хийж, цахим хэлбэрээр 20154 хүнд хүргэсэн. | Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын хүртээмж нэмэгдсэн байна. | 0.2 | 0.0 | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 11 удаагийн сургалтаар 548 албан хаагч, иргэнийг хамруулсан.<br>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан аян, арга хэмжээний хүрээнд шинээр бэлтгэсэн шторкыг орон нутгийн телевизээр 3400 удаагийн давтамжтайгаар цацаж, цахим сүлжээнд постер, шторк, нийтлэлүүд 64300 орчим иргэнд хүрсэн байна.<br>**Үр дүн:** Дархан-Уул аймгийн ЗДТГ "Дэвжээ" тэмцээнийг 8 байгууллагын дунд зохион байгуулсан. | 100% |
| | ***3.4.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлж, иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.*** | | | | | | | | | | | |
| 136 | ЗГҮАХ-4.3 АЗДҮАХ-3.4.3.2 | Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна | | Цагдаагийн газар | ОНТ, ГХЗУС АЗЗ-өөс | 29.9 | Урьдчилан сэргийлэх чиглэлээр 18 арга хэмжээ, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, 75 удаагийн сургалт явуулсан | Устгалын ажлыг зохион байгуулна | 10.0 | 29.9 | Хар тамхи, мансууралтай тэмцэх чиглэлээр "Устгал" арга хэмжээг 450 га талбайд гар аргаар болон техникээр ЦЕГ-ын ХТТГ, Шарын гол, Орхон, Хонгор, Дархан сумын ЗДТГ, НААУГ, УГТЭШХүрээлэн зэрэг байгууллагын нийт 35 албан хаагчийг дайчлан хийж гүйцэтгэлээ. Арга хэмжээний зардал 29.9 сая төгрөгийг аймгийн ГХУСАЗСЗ-өөс гаргаж санхүүжүүлсэн.<br>**Үр дүн:** Хар тамхи, мансууралтай тэмцэх чиглэлээр "Устгал" арга хэмжээг 450 га талбайд гар аргаар болон техникээр хориотой ургамлын устгал хийсэн. | 100% |
| 137 | ЗГҮАХ-4.3 АЗДҮАХ-3.4.3.3 | Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | | Цагдаагийн газар | ОНТ, ГХЗУС АЗЗ-өөс | | Урьдчилан сэргийлэх чиглэлээр 18 арга хэмжээ, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, 75 удаагийн сургалт явуулсан | Урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулна. /хэсэгчилсэн, тусгай арга хэмжээ, зөвлөгөөн | 2.5 | 0.0 | ЦЕГ-аас зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд 5 удаа хяналт шалгалтыг байгуулж, "Буудал" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд биеэ үнэлэлт зохион байгуулсан 1 гэмт хэргийг илрүүлэн шүүхээр шийдвэрлүүллээ.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх "Нууцалъя" аяны хүрээнд 3 удаагийн сургалтыг хийж 310 хүнд мэдээлэл өглөө. Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн 3, үйлдэж болзошгүй сэжигтэй 4 этгээдийг хяналтад авч "Хяналтын систем"-д 6 этгээдийн мэдээллийг оруулаа. | 100% |
| 138 | ЗГҮАХ-4.3 АЗДҮАХ-3.4.3.4 | Архинд донтох эмгэгтэй | | АЗДТГ, Цагдаагийн газар | ОНТХО | 266.3 | Архинд донтох эмгэгтэй 135 иргэнийг бүртгэлд | Архинд донтох эмгэгтэй 22 иргэнийг албадан | 246.6 | 266.3 | Төв аймгийн Мааньт сум дахь Албадан эмчилгээний төвд 12 иргэнийг хамруулж 1.1 сая төгрөгийг зарцууллаа.<br>Зорилтот бүлгийн иргэдэд зориулсан "Жаргалтай амьдрах төв"-ийг | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэдийг албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулах, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгүүдэд хяналт шалгалт хийнэ. | | | | | судалгаанд хамруулсан | эмчилгээнд хамруулж, "Жаргалтай амьдрах төв" байгуулна. | | | байгуулахаар төлөвлөн аймгийн ГХУСАЗЗ-ийн 2023 оны төсөвт үйл ажиллагааны зардал 138.6 сая төгрөгийг тусган 4 дүгээр улирлын дулаан, цахилгааны зэрэг тогтмол зардлыг гаргахаар төлөвлөн ажиллаж байна.<br>Жаргалтай амьдрал төв байгуулах ажлын хүрээнд барилгын засварын ажлыг 105.0 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авах ажилд 161.3 сая төгрөг зарцуулаад байна.<br>**Үр дүн:** Жаргалтай амьдрал төвийн барилгын их засвар тоног төхөөрөмж нийлүүлэх ажил бүрэн дууссан. Үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон. | 100% |
| 139 | МУХТЖҮЧ-6.3.1, ЗГҮАХ-4.3.2 | Дулааны цахилгаан станц, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг дотоодын цэргийн хамгаалалтад авах | | ДЦС, Дархан Ус Суваг ХК | - | | - | Арга хэмжээний хэрэгжилт 100% биелсэн байна. | - | | Дархан-Ус суваг ХК-ий гүний 18 худаг, 2 өргөгч станцыг Дархан-Уул аймгийн дотоодын цэргийн 822 дугаар тусгай салбарын хамгаалалтад 24 цагаар хяналт тавин ажиллаж байна.<br>"Дарханы Дулааны Цахилгаан Станц" ТӨҮГ-ыг дотоодын цэргийн хамгаалалтад шилжүүлэх хүсэлтийг холбогдох орон тоо, зардлын судалгааны хамт Дотоодын цэргийн штабт хүргүүлээ. Тус штабаас хамгаалалтад авах боломжтой ба шаардлагатай төсвийг ирэх оны орон нутгийн болон хамгаалуулагч байгууллагын төсөвт тусган шийдвэрлэх, холбогдох бэлтгэлийг хангах боломжтой эсэх талар саналаа ирүүлэх тухай 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 2/2099 дугээр албан бичгийг ирүүлсэн болно.<br>Аймгийн Засаг даргаас 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 1-10/807 дугаар албан бичгээр Монгол улсын Засгийн газрын 283 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн 7 дугаар хэсгийн 7.2 дахь заалтад заасан нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай зардлыг хамгаалуулагч байгууллага шийдвэрлэх боломжтой бөгөөд хамгаалалтад авахыг дэмжиж байгаа тухай албан бичгийг Дотоодын цэргийн штабт хүргүүллээ. | 70% |
| 140 | МУХТЖҮЧ-7.4.1, ЗГҮАХ-4.3.2 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох тогтолцоог бэхжүүлж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх | | Цагдаагийн газар | УТХО | 2,675.2 | Цагдаагийн газрын барилгын өргөтгөл 70% гүйцэтгэлтэй | Цагдаагийн газрын барилгын өргөтгөлийг ашиглалтад оруулна. | - | 2,675.2 | Аймгийн Цагдаагийн газрын барилгын өргөтгөлийн ажлыг 2022 оны 12 дугаар сард бүрэн ашиглалтад оруулсан. Тус барилга нь 24.0 x 11.50м хэмжээтэй, зоорьтой, 3 давхар барилга. Төсөвт өртөг нь 2.1 тэрбум төгрөг.<br>**Үр дүн:** Стандарт нийцсэн өрөө тасалгаагаар хангагдсан. | 100% |
| | | | | | | | | | | | | |
| | **ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | |
| | **4.1. НОГООН ХӨГЖИЛ** | | | | | | | | | | | |
| | ***4.1.1.Усны нөөц, чанарын хяналтыг сайжруулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах, зөв зохистой ашиглах менежментийг хэрэгжүүлнэ.*** | | | | | | | | | | | |
| 141 | ЗГҮАХ-5.1.3, АХҮЧ-6.1, АЗДҮАХ-4.1.1.1 | Булаг шандын эхийг 4 газарт хамгаална. | | АЗДТГ-ын ХБТХОХ, БОАЖГ | ОНТ | | 3-н булаг шандын эхийг хашаажуулсан. | 3-н булаг шандын эхийг тохижуулна. | 10.0 | 10.0 | 2023 онд Хонгор сумын 2 дугаар багийн нутаг Могойн голын дээд болон доод 2 булгийг Дархан төмөрлөгийн үйлдвэр ХХК тохижуулсан.<br>Дархан сумын Малчин багийн нутаг Дархан-2 өртөөний орчимд байрлах Ужим булгийг Монголын ээмгэйчүүдийн манлайлал сан төслөөс санхүүжүүлэн Дархан сумын ахмадын хорооны ээмгэй манлайлал ТТБайгууллагаас тохижуулсан.<br>**Үр дүн:** Нийт 3 булаг тохижуулсан. | 100% |
| 142 | | Усны тоо бүртгэлийн ажлыг жил бүр зохион байгуулна. | | БОАЖГ, Хараа өрөө голын сав газрын захиргаа | ОНТ | 0.0 | Усны тоо бүртгэлийн ажлыг жил бүр зохион байгуулсан. | Усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулна. | 3.2 | 0.0 | Аймгийн хэмжээнд усны тоо бүртгэлийн ажлыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 07-ны өдрийн хооронд зохион байгуулж, нийт 519 уст цэгийг тоо тоолж, тоо бүртгэлд бүртгэлээ. Үүнд:<br>1. Газар доорх усны эх үүсвэр / Инженерийн хийцтэй худаг / - 429<br>2. Гол горхи –27<br>3. Булаг –32<br>4. Услалтын систем - 5<br>5. Нуур- 3<br>6.Цэвэрлэх байгууламж – 6<br>7. Үерийн хамгаалалт - 9<br>8.Усан сан – 8<br>2023 онд мэдээллийн шинэчлэл баяжилт хийсэн.<br>**Үр дүн:** 2022 онд зохион байгуулж, 2023 онд мэдээллийн санд | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | баяжилт хийсэн. | |
| 143 | ЗГҮАХ-5.1.3, АХҮЧ-6.1 АЗДҮАХ-4.1.1.2 | Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал, тоног төхөөрөмжийг шинэчлэн байнгын ашиглалтад оруулна. | | АЗДТГ-ын ХШҮДАХ | - | | Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал нэмэгдэнэ. | Цэвэрлэх байгууламжаас гарах цэвэрлэсэн ус, лагийн дахин ашиглалт нэмэгдэнэ. | - | | Азийн хөгжлийн банкнаас гэрээ байгуулах зөвшөөрөл ирж Барилга, Хот Байгуулалтын Яам болон "Байгууламж" ХХК-ны хооронд 2022 оны 10 сарын 26-ны өдөр Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламж, насос станц болон 12 сарын зүгшрүүлэлтийн дэмжлэг үзүүлэх багцын үлдэгдэл ажлыг хийж дуусгах №А1-1 2022/499 дугаартай гэрээг 12.926.000.246.00 төгрөгийн өртөгт ажлыг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан.<br>Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, насос станцын засвар шинэчлэлийн ажлын хүрээнд 41 барилга байгууламжийн шинэчлэл хийгдэхээс 23 барилгын ажил дуусаж, 15 барилгын ажил үргэлжлэн хийгдэж, 3 барилгын ажил бусад ажилтай уялдаа хамааралтайгаар эхлээгүй байна. Барилгын ажил дууссан барилга байгууламжуудад тоног төхөөрөмж угсралтын ажил үргэлжлэн хийгдэж байна.<br>Барилга угсралтын ажлын явцын гүйцэтгэл:<br>•Үндсэн барилга угсралтын ажил: 95%<br>•Барилгын гадна дотор засал: 90%<br>•Процессын шугам хоолой угсралт: 85%<br>•Механик тоног төхөөрөмж угсралт: 85%<br>•Агааржуулалт салхивч угсралтын ажил: 98%<br>•Гэрэлтүүлэг, холбоо дохиолол угсралт: 85%<br>•Буцаан дүүргэлт газар шорооны ажил: 90%<br>•Тоног төхөөрөмжийн худалдан авалт: 87%<br>Төслийн хэмжээнд нийт гүйцэтгэл 95%-тай байна.<br>**Үр дүн**: 2024 оны I-р улиралд Дархан хотын төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажил бүрэн дуусаж ашиглалтад оруулна. | 90% |
| | ***4.1.2. Байгаль орчныг хамгаалан, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглаж, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.*** | | | | | | | | | | | |
| 144 | МУХТЖҮЧ-6.2.5 ЗГҮАХ-5.1.5, АХҮЧ-6.2.1, 6.2.2, 6.2.3 АЗДҮАХ-4.1.2.7 | Ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойн хомстол, доройтлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх | | АЗДТГ, Захирагчийн ажлын алба | ОНТ | 286.5 | 3,5 га талбайд "Ногоон паспорт-Ногоон төгөл"-д арчилгаа, хамгаалалт хийгдсэн. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 500000 ширхэг мод тарина. | 500.0 | 286.5 | "Ногоон Дархан-2032" хөтөлбөрийн хүрээнд 2023 онд шинээр 2 төгөл байгуулагдаж бүх нийтээр мод үндэсний өдрийн хүрээнд 325,1 мян.ширхэг мод бут тарьсан.<br>Улсын төсвийн хөрөнгө, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал, Хонгор сумын сум хөгжүүлэх сангийн нийт 131,4 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийгдсэн 4 га талбайд навчит модны суулгацаар ойн зурвас, 42 га газрын шилмүүст модны ойжуулалтын ажил, 50 га талбайд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй байгуулах гэрээнд 3 жилийн хугацаанд ургалтыг хариуцах асуудлыг тусгаж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>**Үр дүн:** Хөтөлбөр хэрэгжсэнээр аймгийн хэмжээнд нийт 11 төгөл байгуулагдаж, бүх нийтээр мод үндэсний өдрийн хүрээнд 546772 ширхэг мод бут тарьсан. Ногоон байгууламжийн хашааг 3 байршилд 4641у/м хашаа шинээр барих ажилд 286.5 сая төгрөг зарцуулсан. | 100% |
| 145 | МУХТЖҮЧ-6.2.4 ЗГҮАХ-5.1.8, АХҮЧ-6.2.1, 6.2.2, 6.2.3 АЗДҮАХ-4.1.2.1 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх | | АЗДТГ-ын ХБТХОХ, БОАЖГ | ОНТ | 30.2 | Эвдэрсэн 587.2 га талбай байгаагаас эвдэрч эзэнгүй орхигдсон нийт 375.3 га талбай байна. | 2 га нөхөн сэргээнэ. | 30.0 | 30.2 | 2023 онд аймгийн хэмжээнд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2 га газар техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр Шарын гол сумаас ирүүлсэн газрын саналын дагуу техникийн тодорхойлолтыг боловсруулан ажлыг гүйцэтгүүлэхээр БОАЖГ-аас 4 удаа зарласан боловч 1 оролцогчоос төсөвт өртгөөс 47 хувиар илүү үнийн санал ирж шаардлага хангаагүй, 3 удаа зарлахад оролцогчийн санал ирээгүй. Нөхөн сэргээлт хийх ажлын төсөв 60.0 сая төгрөг.<br>"Хүрээлэн буй орчны эсрэг" гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хууль бус олборлолттой тэмцэх, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу БОАЖГ, Цагдаагийн газар болон Хонгор, Шарын гол сумдын Засаг даргын Тамгын газруудтай хамтран 6 удаагийн нэгдсэн хяналт шалгалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 15 албан хаагч ажилласан.<br>"Хүрээлэн байгаа орчны эсрэг" гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны 04 сарын 06-ний өдрийн 01-А/87 дугаартай захирамжаар "Хүрээлэн байгаа орчны эсрэг" гэмт хэрэг, зөрчил, ой хээрийн түймэр зэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашигт малтмалын нөөц, ордтой, ойн сан бүхий Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал, Баянгол, Бугант, Хүдэр, Жавхлант, сумуудтай холбосон авто замын гол зангилаа бүхий тодорхой газарт Шарын гол сумын Санжинт баг "Цагаан хөтөл" гэх газарт Хяналтын 1 дүгээр цэг, Хонгор сумын 2 дугаар баг "Цэхэр цөөрөм" гэх газарт Хяналтын 2 дугаар цэг, Хонгор сумын 2 дугаар баг "Бичигт хад" гэх газарт Хяналтын 3 дугаар цэгт 24 цагийн үйл ажиллагаатай, сумдын Засаг даргын тамгын газрын ажилтан, байгаль хамгаалагч нар үүрэг гүйцэтгэж ажиллахад шаардагдах зардалд 30,2 сая төгрөгийг зардал зарцуулаад байна. **Үр дүн:** 6 удаагийн нэгдсэн хяналт шалгалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 15 албан хаагч ажиллаж, шаардагдах зардалд 30,2 сая төгрөгийг зарцуулсан. | |
| 146 | ЗГҮАХ-5.1.9, АХҮЧ-6.2.1, 6.2.2, 6.2.3 АЗДҮАХ-4.1.2.3 | Үржил шимтэй газрыг хамгаалж ойжуулалтын ажлыг 132 га талбайд хийнэ. | | БОАЖГ, Сум дундын ойн анги | Улсын төсөв, ОНХСан | 50.0 | Ойжуулалт 21 га талбайд хийгдсэн. | Шилмүүст мод- 20 га, Байгаль сэргэн ургах талбай-10 га хийнэ. | 90.4 | 50.0 | Улсын төсвийн 36,0 сая.төгрөгийн хөрөнгөөр байгалийн сэргэн ургалтад дэмжих ажлыг 50 га талбайд ойн мэргэжлийн байгууллагууд шон татаж зурвас гаргах, хөрсний өнгөн хэсгийг хуулж талбар гаргах, хөрсийг сийрүүлэх, уг талбарт нарс, хусны үр суулгаж хөнгөн хөрсөөр хучих аргаар гүйцэтгэж, ажлын хэмжээ, үр дүнд орон нутгаас гүйцэтгэлийн акт үйлдэж, Ойн газарт хүргүүлсэн. **Үр дүн:** 50 га талбайд үрийн талбай тусгаарласан. | 100% |
| 147 | МУХТЖҮЧ-6.2.1 ЗГҮАХ-5.1.5, АХҮЧ-6.2.1, 6.2.2, 6.2.3 АЗДҮАХ-4.1.2.4 | Цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах | | АЗДТГ-ын ХБТХОХ | ОНХСан | 45.0 | 9 га талбайд ойн зурвас хийгдсэн. | Ойн зурвас 10 га талбайд хийнэ. | 20.8 | 45.0 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 45,0 сая.төгрөгийн зардлаар 4 га талбайд цөлжилтийг сааруулах зорилгоор навчит модны суулгацаар ойн зурвас байгуулсан. "Ногоон Дархан-2032" хөтөлбөрийн хүрээнд 5.2.3 дахь заалтыг үндэслэн 5,2 га талбайд авто замыг хамгаалах ойн зурвас байгуулах ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй байгуулах гэрээнд 3 жилийн хугацаанд ургалтыг хариуцуулж байна. **Үр дүн:** Цөлжилтийг сааруулах зорилгоор 4 га, авто замын дагуу 5.2 га талбайд ойн зурвас байгуулсан. | 100% |
| 148 | ЗГҮАХ-5.1.9, АХҮЧ-6.2.1, 6.2.2, 6.2.3 АЗДҮАХ-4.1.2.6 | Ойжуулалт нөхөн сэргээлтийн ажлыг 20 га-д хийж ойг хамгаалах арга хэмжээг жилд 10-с доошгүй удаа зохион байгуулна. | | БОАЖГ, Сум дундын ойн анги | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | 20.5 | 74 нөхөрлөл, 7 ойн мэргэжлийн байгууллага 68,0 мян.га талбайг хамгаалдаг. | Ойжуулалт нөхөн сэргээлт 5 га-д хийж хамгаалах арга хэмжээг 13-с доошгүй удаа хийнэ. | 23.0 | 20.5 | БОХНСАХЗардлаар 10 га, Хонгор сумын сум хөгжүүлэх сангийн зардлаар 32 га талбайд шилмүүст модны ойжуулалтын ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй байгуулах гэрээнд 3 жилийн хугацаанд ургалтыг хариуцуулсан. **Үр дүн:** 42 га талбайд доройтсон ойг нөхөн сэргээх ойжуулалтын ажил гүйцэтгэсэн. | 100% |
| | | ***4.1.3. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг шинээр мод тарьж нэмэгдүүлнэ.*** | | | | | | | | | | |
| 149 | МУХТЖҮЧ-6.2.5 ЗГҮАХ-5.1.5, АХҮЧ-6.2.3, АЗДҮАХ-4.1.3.1, 4.1.3.3 | 15 га талбайг тусгаарлаж, Сор, шилмэл модны нэг дүгээр зэргийн үр бэлтгэнэ. | | Сум дундын ойн анги | БОХНСАХЗ | 2.8 | 2020 онд үрийн талбай байгуулах ажил хийгдээгүй. | Сор, шилмэл модны 1 дүгээр зэргийн үр бэлтгэх зорилгоор үр түүх байнгын 5 га талбайг тусгаарлана | 3.2 | 2.8 | Хонгор сумын Домогт гэх газар ойн сан гэрээгээр эзэмшигч "Домогт Шарын гол" ХХК-тай гэрээ байгуулж, 2 га үрийн байнгын талбай тусгаарлах ажилд 2.8 сая төгрөг зарцуулсан. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр үрийн талбай тусгаарласан 67 га талбайг тухайн ойн сан гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөлд хариуцуулан хүлээлгэн өгч, сор шилмэл модны үр түүх талбайн мэдээллийг гаргасан. **Үр дүн:** 2 га талбайд сор, шилмэл модны үрийн талбай тусгаарлах ажлыг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж, их үрийн жилд 1-р зэргийн нарс модны үр 3-5 кг түүх боломжтойгоор болсон. Орон нутагт 67 га үрийн талбайг тухайн нөхөрлөлд хариуцуулан үр түүх боломжийг бий болгосон. | 100% |
| 150 | | Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хилийн цэс тогтоон, ойн мэдээллийн сан шинэчилнэ. | | БОАЖГ, Сум дундын ойн анги | УТХО | | Ойн сангийн гэрээгээр эзэмшигч 6 нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөг баталсан. | Ойн сан 81997 га талбайд ой зохион байгуулалт хийнэ. | 41.8 | | 2023 оны байдлаар ойн менежментийн төлөвлөгөөтэй 46 ойн нөхөрлөл үйл ажиллагаа явуулж байна. Ойн сангийн гэрээгээр эзэмшигч иргэдийн нөхөрлөлийн мэдээллийг eic.mn БОАЖЯ-ны мэдээллийн санд шинэчлэн байршуулсан. Ойн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөр 10 жил тутам хийгдэх ой зохион байгуулалтын ажлыг "Аглаг ой" ХХК ойн мэргэжлийн байгууллага 82,0 мян.га талбайн ойн санд хээрийн судалгааны ажил бүрэн дууссан. **Үр дүн:** Аймгийн хэмжээнд 46 ойн нөхөрлөл ойн менежментийн төлөвлөгөөгөө боловсруулах арга зүйн зөвлөгөө өгч, ойн | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | мэдээллийн санг шинэчилнэ. Ойн менежментийн төлөвлөгөөний суурь мэдээлэл болох ой зохион байгуулалт 82,0 мян.га талбайд хийгдсэн. | |
| 151 | ЗГҮАХ-5.1.5, АХҮЧ-6.2.3, АЗДҮАХ-4.1.3.4 | Аймгийн хэмжээнд мод орлох хямд, эдэлгээтэй материалын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин ажиллана. | | АЗДТГ-ын ХБТХОХ, БОАЖГ | УТХО, Олон Улсын төсөл, ААНБ | | Түлшний мод хэрэглэдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын модны эрэлт нийлүүлэлтийн судалгаа хийгдсэн. | Мод орлох хямд, эдэлгээтэй материалын үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана. | - | | 2023 онд барилга, байгууламж барих ажилд дахин боловсруулсан бүтээгдэхүүн ашиглах техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт тусгах талаар чиглэл, зөвлөмжийг Орон нутгийн өмчийн газарт албан бичгээр хүргүүлсэн.<br>**Үр дүн:** 12 га талбайд хамгаалалтын хашааг мод орлох бүтээгдэхүүнээр хийсэн. | 100% |
| | ***4.1.4. Ойн түймэр, хөнөөлт шавж өвчнөөс хамгаалж, ойг хомсдол, доройтлоос сэргийлнэ.*** | | | | | | | | | | | |
| 152 | АЗДҮАХ - 4.1.4.1 | Ойн түймрээс урьдчилан сэргийлж, тандалт судалгааг хийж ойн цэвэрлэгээний ажлыг 155 га талбайд хийнэ. | | Сум дундын ойн анги | - | 15.5 | 4 ойн мэргэжлийн байгууллага, 3 нөхөрлөлд 59 га талбайд ойн цэвэрлэгээ хийлгэсэн. | 35га талбайд ойн цэвэрлэгээний ажил хийлгэж ой, хээрийн түймэр гарах эрсдэлийг бууруулна. | - | 15.5 | Ой, түймрээс урьдчилсан сэргийлж, тандалт судалгааг хийх ажлыг хууралшилтын улирал хариуцлагатай жижүүрийг ажиллуулж, мэдээг Ойн газарт цагийн байдлыг 60 удаа мэдээлж ажилласан.<br>2023 онд 300 га талбайд ойн цэвэрлэгээний ажлаар иргэдийн түлшинд зориулж мод бэлтгэх эрхийн бичгийг 716 иргэн, ААНБ-д нарс 1836 м.куб, улиас 1018 м.куб, хус 16 м.куб нийт 2870 м.куб олгож, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 15,566,447,0 төгрөг төвлөрсөн байна.<br>**Үр дүн:** Ойн цэвэрлэгээний ажлыг 300 га талбайд хийж, ойн нөөц ашигласны төлбөр 15.5 сая.төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. | 100% |
| 153 | МУХТЖҮЧ-6.2.5 ЗГҮАХ-5.1.5 АЗДҮАХ - 4.1.4.2 | Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг 3000га талбайд хийнэ. | | ХБТХОХ, БОАЖГ | БОХНС АХЗардал | 6.6 | Ойн хортон шавжийн тэмцлийн ажил хийгдээгүй. | 3000га талбайд хийнэ. | 10.0 | 6.6 | 2023 онд Дархан-Уул аймгийн ойн сангийн хортон шавжийн тархалтын тоймчилсон ажиглалт, судалгааг улсын төсвийн хөрөнгөөр 13,7 мян.га талбайд, БОХНСАХЗардлаар 82,0 мян.га талбайн хортон шавжийн тархалт бүхий газар нутгийг тогтоосон.<br>Аймгийн хэмжээнд тэмцлийн ажил явуулах голомт бүхий талбай байхгүй. Тархалттай талбай 1500 га талбай тогтоосон.<br>**Үр дүн:** Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох тоймчилсон судалгааны ажлыг 82,0 мян.га талбайд хийж гүйцэтгэснээр 2024 онд тэмцэх талбайн хэмжээ 1500 хүртэл га талбай тодорхойлж гаргасан. | 100% |
| | **4.2. НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ, БҮТЭЭМЖТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ НОГООН ХӨГЖИЛ** | | | | | | | | | | | |
| | ***4.2.1. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлнэ.*** | | | | | | | | | | | |
| 154 | ЗГҮАХ-5.1.12 АХҮЧ-6.3.1 АЗДҮАХ - 4.2.1.1 | Уур амьсгалын хуурайшилтыг бууруулж, хөрсний чийгийг нэмэгдүүлэн, ургамлын ургалтыг сайжруулахаар цаг агаарт зориудаар нөлөөлнө. | | Ус, цаг уур, орчны шинжилгээний төв | ОНТ | 0.0 | Сүүлийн жилүүдэд ой хээрийн түймэр гараагүй байгалийн жамаар орох тунадас 17-20 мм нэмэгдсэн. | Тунадасны хэмжээг 26 мм-ээр нэмэгдүүлнэ. | 1.0 | 0.0 | 2023 оны 4-5 дугаар саруудад орсон хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас 2 дахин их, хуурайшилт бага байсан тул цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагаа 6-р сард эхлүүлсэн. Ургамлын эмзэг үе, ус чийг их шаарддаг 6-р сард 2 удаа ажиллаж 8.4 мм тунадас нэмэгдүүлснээр /эдийн засгийн үр ашгийн тооцоогоор 275.1 мянган м3 ус буюу 55.0 сая төгрөгөөр үнэлэгдэх/ хуурайшилтын зэрэг бууруч хөрсний чийгийн хангамж сайжирсан.<br>Хуурайшилт багасч ой хээрийн түймэр гараагүй. Аймгийн хэмжээнд бэлчээрийн ургамлын ургац олон жилийн дунджаас 1-2 дахин, буудайн ургац дунджаас 2-3 ц/га -аар илүү хурааж авсан.<br>**Үр дүн:** Сүүлийн 3 жилийн 32.4мм тунадас нэмэгдүүлж зорилтот түвшинд хүрсэн. | 100% |
| 155 | ЗГҮАХ-5.1.12 АХҮЧ-6.3.1 АЗДҮАХ - 4.2.1.2 | Цаг агаарын аюултай үзэгдлээс учруулах хохирлыг багасах, хэрэглэгчийн тоог нэмэгдүүлж, "Цахим сэрэмжлүүлэг-Дархан" аппликейшнийг хөгжүүлнэ. | | Ус, цаг уур, орчны шинжилгээний төв | ОНТ | 0.2 | Аймаг, сумдын ОК-ын 59, 511 малчинд нийт 4260 удаа мэдээлэл хүргэж үйлчилсэн. | Цаг агаарын аюултай үзэгдлээс учруулах хохирлыг багасгах, хэрэглэгчийн тоог нэмэгдүүлнэ. | 0.2 | 0.2 | Цаг агаарын аюултай үзэгдлийн сэрэмжлүүлэг мэдээ 4, анхааруулга мэдээ 15 нийт 19 мэдээллийг "ЦАГ АГААР" аппликейшнд тавьж хэрэглэгчдэд онцгойлон анхааруулж байна.<br>Цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээ болон хавар шар усны. 7 дугаар сард голууд үерийн аюултай түвшинд хүрч үерлэхэд 352 удаагийн давтамжтай анхааруулга өгч иргэдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэрэмжлүүлсэн.<br>**Үр дүн:** нийт 7335 удаагийн мэдээллээр үйлчилж зорилтот түвшинд 100% хүрсэн. | 100% |
| | ***4.2.2. Хог хаягдлын менежментийг сайжруулж, хог дахин боловсруулах үйлдвэрлэлийн ажлыг эхлүүлнэ.*** | | | | | | | | | | | |
| | | Хог дахин боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулж, хувийн хэвшлийн оролцоотой хог дахин | | АЗДТГ-ын ХБТХОХ, Захирагчийн ажлын алба, БОАЖГ | БОХНС 3, Хувийн хэвшлийн | 1,200.0 | Хог дахин боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг, төсөв байхгүй | Хог дахин боловсруулах үйлдвэр шинээр барих ажлыг хэрэгжилт 20 | - | | 2023 онд хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.Үүнд:<br>Орон нутгийн төсвийн 0.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэл /"Сан оргиу" ХХК/ 95 хувь, | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 156 | ЗГҮАХ 6.1.9.1 АЗДҮАХ 4.2.2.1 | боловсруулах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулна. | | | хөрөнгө оруулалт, Гадаадын хөрөнгө оруулалт | | | хувьд хүрсэн байна. | | 1,200.0 | 0.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар аюултай хог хаягдлыг шатаах зуух барилгын ажлын гүйцэтгэл /"Технологи бридж" ХХК/ 95 хувь гүйцэтгэлтэй байна.<br>-Европын Холбооны санхүүжилттэй "НАЙРАМДАЛ" төслийн II зорилт буюу Иргэдийн оролцоот засаглалыг дэмжих ажлын төлөвлөгөөний дагуу "Хоггүй Дарханыг хамтдаа бүтээе" сэдвээр Дархан форум хэлэлцүүлгийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.<br>Дархан сумын 10-р багт Хогоо ангилья-Багасгая төслийн хүрээнд иргэдэд хогоо хэрхэн ангилж мөнгө болгох талаарх сургалт, сурталчилгааны ажилд 20.0 сая төгрөг зарцуулсан.<br>**Үр дүн:** Барaат хогийн цэгт ажиллах Экскаватор, Бульдозер нийлүүлэх 1,2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 2 техникийг хүлээлгэн өгсөн. | |
| 157 | ЗГҮАХ 6.1.9 АХҮЧ-6.3.3 АЗДҮАХ-4.2.2.2 | Хог тээврийн тусгай зориулалтын автомашины парк шинэчлэлтийг ажлыг үе шаттай хийнэ. | | АЗДТГ | ОНТ | 2,100.0 | НААҮГ нийт 25 тээврийн хэрэгсэлтэй. | Хог тээврийн тусгай зориулалтын 3-н авто машин нийлүүлнэ. | 489.0 | 2,100.0 | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Дархан хотын тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ"-т Хог тээврийн 8м3 багтаамжтай тусгай зориулалтын 4 авто машин, хово автомашин 1ш, тусгай зориулалтын ковш 1ш, хог цэвэрлэгээний тусгай зориулалтын 3ш техник нийлүүлэх ажилд 500.0 сая төгрөг, ухах, ачиж буулгах зориулалттай гинжит экскаваторыг 825 сая, Хятад улсад үйлдвэрлэсэн SHEHWA брэндийн TYS 165-3 HW маркийн түрэх зориулалттай бульдозерыг 388 сая төгрөгөөр тус тус нийлүүлсэн.<br>**Үр дүн:** "Дархан хот тохижилт " ОНӨААТҮГ- Хог тээврийн тусгай зориулалтын автомашины парк шинэчлэлтийн ажилд 11 техник нийлүүлэх ажилд 2.1 тэрбум төгрөг зарцуулаад байна. | 100% |
| 158 | ЗГҮАХ 6.1.9 АХҮЧ-6.3.3 АЗДҮАХ-4.2.2.3 | "Цэвэр хот" дэд хөтөлбөр батлагдсан. | | АЗДТГ, БОАЖГ | БОХНС АЗ, ОНТ | 188.8 | Жил бүр сургалт сурталчилгааг иргэд, олон нийтийн дунд явуулна. ТВ шторк бэлэн болсон байна. | Дархан, Орхон, Шарын гол, Хонгор сумдад дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна. | 2.0 | 188.8 | 2023 онд Барaат хогийн цэгийн гадна цахилгаан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд ОНХО-188,799,746 төгрөгийн ажил хийгдсэн.<br>Аймгийн Засаг даргын 2023 оны 01-А/57 дугаар "Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай" захирамж, Онцгой комиссын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Дархан сумын 5,6,7,8,9,10, 12,13,14,15 дугаар багуудын нутаг дэвсгэрт байрлах үерийн усгаас хамгаалах ил сувгийн цэвэрлэгээг түлш эрчим хүчний албаны мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүн болох "ДДЦС" ТӨХК, "ДДС" ТӨХК, "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн Төвийн бүсийн салбар, "ДСЦТС" ХК, "Дархан-Ус суваг "ХК-ийн ажилтан албан хаагч нар хийж гүйцэтгэж, төр хувийн хэвшлийн санхүүжилт 500 орчим сая төгрөг зардал гаргасан Дархан, Орхон, Шарын гол, Хонгор сумдад дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулсан ажиллалаа. | 100% |
| 159 | ЗГҮАХ 6.1.9 АХҮЧ-6.3.3 АЗДҮАХ-4.2.2.4 | "Шарилжгүй Дархан" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн жил болгон 150 га багагүй талбайд шарилж устгалыг хийнэ. | | АЗДТГ | БОХНС 3 | 19.1 | Жилд 130-150га талбайд шарилж устгалыг хийдэг. | Дархан сумын хэмжээнд нийт 200га талбайд шарилж устгалыг хийнэ | 10.0 | 19 1 | 2023 онд 18,1 сая төгрөгийг зарцуулж нийтийн аж ахуй үйлчилгээний газраас хог ургамал буюу шарилжийг устгах ажлын хүрээнд Дархан сумын нутаг дэвсгэрийн 640 га талбайд устгалд хийж байна.<br>**Үр дүн:** Дархан сумын хэмжээнд 640 га талбайд шарилж устгалын ажил хийж, 47,9 сая төгрөг зарцуулсан. | 100% |
| 160 | ЗГҮАХ 6.1.9.2 АЗДҮАХ-4.2.2. | Гэр хорооллын айл өрхийн хог татан авах, үнс хадгалах зориулалтын 2000 савыг гэр хорооллын айл өрхүүдэд үе шаттайгаар нийлүүлнэ. | | Захирагчийн ажлын алба, НААҮГ | ОНТ | | 100 ш үнсний савыг Дархан сумын 2 багт нийлүүлсэн. | Үнсний савыг гэр хорооллын 600 айлд нийлүүлнэ. | 30.0 | 19.6 | 2021 онд гэр хорооллын айл өрхийн хогийг татан авах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 130.0 сая.төг-ийн хөрөнгө оруулалтаар 18м3 багтаамжтай Хово маркийн авто машин, 2022 онд 8ш техникээр парк шинэчлэлтийг нэмэгдүүлэх ажилд 1927.0 сая.төг, 2023 онд иргэдийн хог хаягдлын боловсролыг дээшлүүлж, хотын өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар /19.6 сая.төг/ 95ш хуванцар хийх савыг бэлэн болгож, нийтийн зээмшлийн зам талбайд байршуулсан.<br>**Үр дүн:** Гэр хорооллын айл өрхийн хог хаягдлын татан авалт сайжирч, орон сууцны иргэд хуванцар савыг ангилдаг хэвшил бий болсон. | 0% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ***4.2.3. Агаарын бохирдлыг бууруулах боломжит судалгааг хийн, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.*** | | | | | | | | | | | |
| 161 | АХҮЧ-3.3.2 АЗДҮАХ-4.2.3.3 | Гэр хорооллын айл өрхүүдийн яндангийн тооллого хийж, төвлөрсөн дэд бүтцэд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | | АЗДТГ-ын ХБТХОХ | ОНТ | 0.0 | Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн ажлыг 2017-2020 онд 3 удаа зохион байгуулсан. | Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн дэд бүтцэд холбох ажлыг хийнэ. | 20.0 | 0.0 | Аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг I улиралд хийж дата мэдээг "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан" www.envpol.mne.gov.mn-д байршуулсан.<br>Үр дүн:<br>1.Аймгийн хэмжээнд галлагаатай 7513 өрх тоологдож өмнөх оноос 356 айл буюу 4.7%-аар нэмэгдсэн.<br>2.15-100кВт хүртэл хүчин чадалтай 34 зуух 1105.0тн нүүрс шатааж өмнөх оноос зуух 1-ээр, түлш 0.8%-аар нэмэгдсэн байна.<br>3.100-4200кВт хүртэл хүчин чадалтай 18 зуух 10533тн нүүрс шатаасанг өмнөх оны дүнтэй харьцуулахад зуухны тоо нэмэгдээгүй шатаасан нүүрсний хэмжээ 2.9%-иар багассан байна.<br>4.4200кВт-аас дээш хүчин чадалтай ДДЦСтанц ТӨХК, Дулаан Шарын гол ТӨХК-уудын 13 зуух 453312тн нүүрс шатаасан нь өмнөх оноос Дулаан Шарын гол ТӨХК 260тн, ДДЦСтанц ТӨХК 94639тн-оор нэмэгдсэн.<br>21255 тээврийн хэрэгсэл тоологдсон бөгөөд өмнөх оноос 8.9%-иар нэмэгдсэн.<br>2024 оны 1 улиралд багтаан агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаад байна.<br>**Үр дүн:** Агаарын бохирдлыг бууруулах нөхцөл боломж бүрдэж байна. | 30% |
| 162 | АХҮЧ-3.3.2 АЗДҮАХ-4.2.3.4 | Байгальд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлнэ. | | ГХБХБГ | УТХО | 0.0 | Дархан сумын 9,10,12 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах 31 дүгээр хорооллын ИШС-ний ажил хийгдсэн. | 31 дүгээр хороололд амины орон сууцны ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлнэ. | - | 0.0 | Дархан сумын 9,10,12-р багийн нутаг дэвсгэрт байрлах амины орон сууцны 31-р хорооллын цэвэр, бохир усны шугам хоолой, цахилгаан хангамж угсрах ажил бүрэн дууссан. Улсын комисс ажиллаж тус хороололд хийгдсэн цахилгаан хангамжийн систем тоноглолыг ашиглагч байгууллага болох "ДСЦТС" ХК-д хүлээлгэн өгсөн.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсөвт 31-р хорооллын төвлөрсөн дулаан хангамж шинээр татах ажилд 11.2 тэрбум төгрөг батлагдсан.<br>**Үр дүн:** Айл өрхүүд цахилгаан эрчим хүчинд холбогдсон, дулаан халаалтыг асуудлыг цахилгаан хангамжаар шийдвэрлэсэн. 2024 онд тус хорооллыг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг эхлүүлнэ. | 100% |
| | ***4.2.4. Ногоон худалдан авалтыг нэмэгдүүлнэ.*** | | | | | | | | | | | |
| 163 | АЗДҮАХ-4.2.4. | Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгөөр байгалийн нөөц баялаг, эрчим хүчний хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлнэ. | | АЗДТГ-ын ХБТХОХ | - | | Орон нутгийн аж ахуй нэгж, байгууллагыг дэмжин ажиллаж, нийт худалдан авалтын 10 хувьд дотоодын аж ахуйн нэгж шалгарсан байна. | Нийт худалдан авалтын 15 хувьд дотоодын аж ахуйн нэгж шалгарсан байна. | - | | ОНӨГ-ын 2021-2023 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 382,193.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 56, өвсний үндэс төслийн хүрээнд хэрэгжих 615.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 18,691.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 61, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3,782.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11, авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3,062.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5, БОХНСАХЗ-аар санхүүжигдэх 654.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10, төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөнөөс давхардсан тоогоор 316 удаагийн тендер сонгон шалгаруулалтыг 100 хувийн гүйцэтгэлтэй, 2,783.0 сая төгрөгийн хэмнэлт, үр ашигтай зохион байгуулан ажиллаж байна.<br>**Үр дүн:** 2021-2023 онд 409,914.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 567 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 2,783.0 сая төгрөгийн хэмнэлтийг гаргасан. | 100% |
| | **ТАВ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | |
| | **5.1. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ** | | | | | | | | | | | |
| | ***5.1.1. Хөрөнгө оруулалтыг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэн, орон нутгийн хөгжлийн таатай орчныг бүрдүүлнэ.*** | | | | | | | | | | | |
| 164 | ЗГҮАХ-6.2.14, АХҮЧ-4.1.2 АЗДҮАХ-5.1.1.1 | Хар металлургийн үйлдвэрийн цогцолбор, Барилга, барилгын материалын үйлдвэрийн цогцолбор, Дархан арьс | | АЗДТГ-ын ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | ЖДҮХС, Хорошоо хөгжүү | | Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг салбараар өнгөрсөн оны мөн үетэй | Салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлийн | 250.0 | | Ажлын байр дэмжих хөнгөлөлттэй зээл"-д 566 иргэн, 132 аж ахуйн нэгж 41.16 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй 3 хувийн хүүтэй зээлийг 3 жилийн хугацаатай арилжааны банкаар дамжуулан олголоо.<br>Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хүрээнд 188 иргэн, аж ахуйн нэгжид 41.8 тэрбум төгрөгийн 5-6 хувийн хүүтэй | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ширний үйлдвэрийн цогцолбор, Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ. | | | лэх сан, ЗБДС | | харьцуулбал дулаан цахилгааны үйлдвэрлэл 6.6 хувь, бусад ашигт малтмалын 68.6 хувиар өссөн байна | бодлогоор дэмжиж ажиллана. | | | хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкаар дамжуулан олголоо.<br>Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд 14 аж ахуйн нэгж 1.7 тэрбум төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд 117 иргэн, аж ахуйн нэгжид 937.4 сая төгрөг, батлан даалттай зээлд 13 аж ахуйн нэгж 2345.7 сая төгрөгөөр хамрагдаж, 3000 гаруй ажлын байр хадгалагдлаа.<br>Дархан арьс ширний цогцолбор ХХК-ийн 180га талбайд "Дархан арьс ширний цогцолбор" үйлдвэрийг байгуулснаар 7500 орчим байнгын ажлын байр, жилдээ 10 сая.ш арьс шир боловсруулах 13 үйлдвэр, 10 мян.тн ноос боловсруулах ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, түүний цэвэрлэх байгууламж, инженерийн дэд бүтцийн барилга байгууламж бий болох бөгөөд эрчим хүч, усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, дулаан хангамж, уурын зуух зэргийг барьж байгуулахад 15.4 сая ам долларын хөрөнгө оруулалтыг хийж, эрчим хүч 95%, дэд станц ажил гүйцэтгэл 90%, ус, дулаан хангамж 70%, бохир ус цэвэрлэх байгууламжийн аэро-танк зэрэг ажлууд өмнөх онд хийгдсэн.<br>Дархан арьс ширний цогцолбор ТӨХК-д аймгаас 25 га талбай газрыг олгож, бүтээн байгуулалтыг дэмжиж ажиллаж байна.<br>Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны эхний 9 сард урьдчилсан гүйцэтгэлээр 537.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 204.4 (61.4%) тэрбум төгрөгөөр өссөн. Үүнд: боловсруулах үйлдвэрлэл 153.5 (65.9%) тэрбум төгрөг, үйлдвэрлэсэн гол нэр төрлийн 34 бүтээгдэхүүнээс алт 4.9 дахин өссөн, гурил, хэвлэл, цахилгаан, дулаан, цэвэр ус, нүүрс, хүдэр, төмрийн бэлдэц, цувимал, элс хайрга, хөнгөн бетон, зуурмаг 5.8-83.6 хувиар тус тус өссөн байна.<br>Хүнсний боловсруулах үйлдвэрлэл: мал төхөөрөх 2, мах боловсруулах 6, мах ангилан савлах 2, хагас боловсруулсан махан бүтээгдэхүүний 21, гурилын 3, гурилан бүтээгдэхүүний 43, сүү сүүн бүтээгдэхүүний 6, ус савлах үйлдвэр 5, хүнсний ногоо боловсруулах 8, жимс жимсгэний шүүс үйлдвэр 1, өндөгний 3, ургамлын цайны 1, нийт 101 үйлдвэр цех үйл ажиллагаа явуулж байна.<br>**Үр дүн:** Бүтээгдэхүүн үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй цуулахад 61.4 хувиар өссөн. | |
| | ***5.1.2 Инженерийн хангамжтай орон сууц, хувийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ*** | | | | | | | | | | | |
| 165 | МУХТЖҮЧ-9.3.2, ЗГҮАХ-3.7.4, 3.7.9, 3.7.13, 6.1.3, АХҮЧ-3.2 АЗДҮАХ-2.7.3.1 | Орон сууц" аймгийн дэд хөтөлбөр батлагдсан. | | ГХБХБГ | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 125,000.0 | Нийт айл өрхийн 55.2% нь инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан. | 400 айлын орон сууц ашиглалтад орсон байна. | 34,600.0 | 125,000.0 | Орон сууц" дэд хөтөлбөрийн хүрээнд тус аймгийн хэмжээнд 2021 онд 318 айлын орон сууц баригдаж 318 айл өрх, 2022 онд 584 айлын орон сууц баригдаж 536 айл өрх, 2023 онд 17 байршилд 1793 айлын нийтийн орон сууц баригдаж байнгын ашиглалтад хүлээн авсан.<br><br>**Үр дүн:** 2021-2023 онд нийт 2647 айлын орон сууц ашиглалтад орсон. 2023 онд нийт 20 байршилд 1939 айлын орон сууц баригдаж байгаагаас 1793 айлын орон сууц ашиглалтад ороод байна. | 100% |
| 166 | | Залуус хороолол төслийг хэрэгжүүлнэ | | АЗДТГ | УТХО | 12,000.0 | 143 га талбайд ерөнхий төлөвлөгөө хийгдэж байна. | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж төвлөрсөн дэд бүтцийг татах ажлыг эхлүүлнэ. | 47,000.0 | 12,000.0 | Дархан сумын 13-р багт Залуус-1 хороолол 102га талбайд, 15-р багт Залуус-2 хороололд 23га талбайд хорооллуудыг төлөвлөн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Инженер геодези ХХК гүйцэтгэж, аймгийн ИТХ-ын 2023.02.10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Иргэдийн орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, орон сууцыг цогцолбор байдлаар барих, авто зогсоол ногоон байгууламж, нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн Залуус 1, 2 хорооллыг төлөвлөсөн. Дархан сумын 13-р баг 29-р хороолол "Залуус-1" хороолол 102 га газарт 8000 айлын нийтийн орон сууц, Дархан сумын 15-р багт Залуус-2 хорооллын 25 га газарт 2000 айлын орон сууц тухайн 2 байршилд төвлөрсөн инженерийн шугам сүлжээ татах ажлыг 77.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2025 онд хэрэгжүүлнэ. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | **Үр дүн:** Залуус хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж батлагдсан. 2022-2025 онд 77.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дэд бүтэц татах ажил хийгдэж байна. | |
| 167 | ЗГҮАХ-6.2.8. АХҮЧ-3.2.2 АЗДҮАХ-5.1.2.4 | Хотын төвийн мал бүхий иргэдийг нийлүүлгэн шилжүүлж шинз суурьшлын бүс байгуулна. | | Дархн сумын ЗДТГ | ОНТ, Хоршоо хөгжүүлэх сан, Төсөл, хөтөлбөр | | "Ноён хонгорт" туслах аж ахуйтай 30-н өрхийн суурьшлын бүс байгуулахаар төлөвлөн цахилгаан хангамж, худаг гаргах ажлыг хийгдэж байна. | Өндөр ашиг шимтэй гахай, шувууны бүтээгдэхүүн иргэдэд нийлүүлэх ложистикийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 200.0 | | Нийт 13 байгууллагын 70 гаруй албан хаагч ажиллаж малтай өрх 85,7 хувь, Гахайтай өрхийн 41,8 хувийг гаргаж дунджаар 64,7 хувийг тус тус гаргасан байна.<br>Хотын төвөөс малаа гаргаагүй өрхийг "Эрчимжсэн мал аж ахуй", "Туслах аж ахуй"-н суурьшлын бүсэд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж, Төвийн гэр хорооллын 5, 6, 7, 8, 15 дугаар багийн нутаг дэвсгэрт мал, туслах аж ахуй (гахай) нэвтрүүлэхгүй байхыг 5, 6, 7, 8, 15 дугаар багийн Засаг дарга нарт үүрэг болгон ажиллаж байна.<br>Туслах аж ахуйн суурьшлын бүсийн худгийг ажилд оруулах ажлыг Орхон сумын ЗДТГ-тай хамтран хэрэгжүүлж тус бүсэд гахайгаа гаргасан 7 өрхөөс хэрэгжилт хангасан 5 иргэний газрын гэрчилгээг гаргууллаа.<br>**Үр дүн:** Мал аж ахуйн суурьшлын бүсэд нийт 31 өрх шилжин суурьшиж ус цахилгаанаар бүрэн хангагдсан. ХХҮГ-тай хамтран хотын төвөөс малаа гаргаагүй өрх малаа зарах хүсэлт ирүүлсэн бөгөөд 1 иргэний малыг малжуулах төсөлд худалдан борлуулах ажлыг гүйцэтгэж 1 өрхийг малгүй болгоод байна.<br>Гэр хорооллын бүсэд байнгын хяналт хийж байна. 2023 оны 10 дугаар сарын байдлаар малтай өрх 90,1 хувь (5.6.7.8.15-р баг), Гахайтай өрхийн 60% хувийг тус тус гаргаад байна. | 90% |
| | ***5.1.3.Түүхий эдийн нөөцөд тулгуурлан, орон нутгийн онцлогт тохирсон эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.*** | | | | | | | | | | | |
| 168 | ЗГҮАХ-6.2.13. АХҮЧ-4.1.3 АЗДҮАХ-5.1.3.1 | Дархан үйлдвэр технологийн парк"-ийн ТЭЗҮ боловсруулж, ҮТП-ын 1, 2 дугаар бүсэд үйлдвэрлэлийг кластер хэлбэрээр хөгжүүлнэ. | | "Дархан үйлдвэр технологийн парк" ОНӨААТҮГ, ХБТХОХ | ОНТ | 0.0 | Дархан Үйлдвэрлэл Технологийн Парк ОНӨААТҮГ нь ТЭЗҮ болон холбогдох бичиг баримтууд одоо хүчин төгөлдөр байгаа тусгай зөвшөөрлийн хугацаа 2022 онд дуусгавар болно. | ТЭЗҮ-ийг боловсруулж, аймгийн ИТХ-ийн хуралдаанаар батлуулна. | 220.0 | 0.0 | Дархан Үйлдвэрлэл Технологийн Парк ОНӨААТҮГ нь ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар боловсруулагдсан. ТЭЗҮ боловсруулахад шаардагдах 220.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй | 0% |
| 169 | ЗГҮАХ-6.2.13. АХҮЧ-4.1.3 АЗДҮАХ-5.1.3.4 | Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж ажиллана. | | АЗДТГ, ГХБХБГ | ЖДҮХС, Хоршоо хөгжүүлэх сан | | Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгч 2 үйлдвэрийг 180.0 сая төгрөгөөр дэмжиж ажилласан. | Нэгээс доошгүй үйлдвэрлэгчийг дэмжиж ажиллана. | 25.0 | | 2023 онд Дархан сумын 13-р баг Үйлдвэрчний 2-р гудамж 203 тоот 1 нэгж талбар 8 га газрыг үйлдвэрлэлийн чиглэлээр газар олгосон.<br>**Үр дүн:** Аймгийн хэмжээнд барилгын материал үйлдвэрлэлийн ААНБ-уудын 2023 онд тусгай зөвшөөрлийн сунгалт болон шинээр авсан бүртгэлийг шинэчлэн гаргалаа. Аймагт тусгай зөвшөөрөлтэй 24 ААНБ, 33 тохирлын гэрчилгээтэй 30 ААНБ барилгын материал үйлдвэрлэл эрхэлж байна Зарим ААНБ хэд хэдэн нэр төрлөөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж тухайн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ авч үйлдвэрлэл эрхэлнэ. Өнгөрсөн оноос 5 ААНБ тохирлын гэрчилгээ авч нэмэгдсэн байна. | 100% |
| 170 | ЗГҮАХ-6.2.13. АХҮЧ-4.1.3 АЗДҮАХ-5.1.3.5 | Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг дахин боловсруулах үйлдвэрлэлийг кластер хэлбэрээр хөгжүүлнэ. | | АЗДТГ-ын ХБТХОХ, ХХААГ | Төсөл, хөтөлбөрүүд, аж ахуйн нэгж, иргэний хөрөнгө | | Төмс, хүнсний ногоо, жимсгэнэ дахин боловсруулах үйлдвэр байхгүй. | Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг дахин боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтворжуулна. | 50.0 | | Салбарын суурь судалгаагаар төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг 32 аж ахуйн нэгж, 1687 иргэн байна Аймгийн хэмжээнд 12.5 мян.тн багтаамжтай 9.0 мян.ш зоорь ашиглагдаж байна. 2023 онд төмс, хүнсний ногоо 7476.2тн, хүнсний ногоо 20005тн ургац хураан авсан. "Хүнсний ногоо" үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүнсний ногооны үйлдвэрлэлээр өрхийн орлогыг нэмэгдүүлэх, баталгаатай үрээр хангах зорилгоор 2023 онд ХХААХҮЯ-аас 126.2 сая.төг-ийн 11 нэр төрлийн хүнсний ногооны үрийг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр үр үржүүлэгч болон тариалан эрхлэгчдэд сумын ХАА-н тасгаар дамжуулан олгосон байна. "Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор арилжааны банкаар дамжуулан 5 жилийн хугацаатай 5 ба 6 хувийн хүүтэй хөрөнгө оруулалтын зээл, 2 жилийн хугацаатай 6 хувийн хүүтэй эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтийг | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | ХХААХҮЯ-д уламжилснаар хүнсний ногооны тариалан эрхлэгч 76 иргэн, 6 аж ахуйн нэгжид 4336.25 сая.төг-ийн зээл аваад байна.<br>Аймгийн хэмжээнд Хүнсний ногоо боловсруулах, нөөшлөх, савлах, хатаах чиглэлээр Мөнхөт үржих зөгий ХХК, Цогт Ану ХХК-ийн Мандуул цех, Амгалан монгол ногоо ХХК, Батбүрэн толгой ХХК 4 аж ахуйн нэгж, Буян-Да хоршоо, Орхон бялхам өгөөж хоршоо 2 хоршоо, 4 иргэн, нийт 29 ажилтантай, жимс жимсгэнэ боловсруулах 1 аж ахуйн нэгж, 2 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.<br>Улаанбаатар хотын Вагро, Газар шим, Дөрвөн өлзий зэрэг хүнсний ногоо боловсруулах томоохон үйлдвэрүүд түхий эдийн цэгийг байршуулж, өргөст хэмх, сонгино, лууван, хүрэн манжин зэрэг бүтээгдэхүүнийг Орхон сумын хүнсний ногооны тариалан эрхлэгчидтэй гэрээлэн түүхий эдийг кластер хэлбэрээр татан төвлөрүүлж байна ХХААГ, "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран зохион байгуулсан "Хүлэмжийн зохистой дадал" сургалтанд нийт 30 хүлэмжийн аж ахуйн эрхлэгчдийг хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүллээ. Бүтээгдэхүүн үйлчилгээг нийтэд таниулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Хөгжлийн шийдэл ТББ-ын санхүүжилтээр Цахим каталогит Батбүрэн толгой, Найрамдал мөөг, аймгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Цэц.мн сайтаар Батбүрэн толгой Наараа кимчи цехийн үйл ажиллагааг сурталчилсан.<br>Жимс, жимсгэнийн үйлдвэрлэл эрхлэгч 5 аж ахуйн нэгж жилд дунджаар 6.9 га талбайд жимс жимсгэнэ тариалж, 21.3тн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлсэн.<br><br>**Үр дүн:** Хүнсний ногоо боловсруулах, нөөшлөх, савлах, хатаах чиглэлээр нийт 4 аж ахуйн нэгж, 2 хоршоо, 4 цех, нийт 29 ажилтантай, жимс жимсгэнэ боловсруулах 1 аж ахуйн нэгж, 2 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотын 3 үйлдвэрт кластер хэлбэрээр түүхий эд бэлтгэн нийлүүлж байна. | |
| 171 | ЗГҮАХ-6.2.13, АХҮЧ-4.1.3 АЗДҮАХ-5.1.3.6 | Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | | ААН, ХХААГ | - | | Махан бүтээгдэхүүн 109 тонн, сүүн бүтээгдэхүүн 190 мян.л, гурил 22244 тонн, талх 420 тонн, нарийн боов 572 тонн үйлдвэрлэсэн байна. | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг 1.0-1.5%-иар нэмэгдүүлнэ | - | | Орон нутгийн хүнсний боловсруулах үйлдвэрийн 2023 оны 12-р сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр махан бүтээгдэхүүн 179.4тн, сүүн бүтээгдэхүүн 123.6 мян.л, гурил 33557.2тн, талх, гурилан бүтээгдэхүүн 1018тн үйлдвэрлэсэн нь 2020 оны суурь түвшинтэй харьцуулахад гурил 39.6%, талх, нарийн боов 8.13%, хиамны үйлдвэрлэл 63.5%-аар өссөн байна. Өвлийн улирлын сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхээр 2022-2023 онд 2 үйлдвэр, 2023-2024 онд 1 үйлдвэр сонгон шалгаруулалтад хамрагдаж, 11-26 малчинтай гэрээ байгуулан үйлдвэрлэлийг тасралтгүй явуулж байна. Хаврын улирлын цаг агаарын нөхцөл байдал, малын тарга тэвээрэгтэй холбоотойгоор малчдаас сүүний нийлүүлэлт 5-р сарын 20-ноос нэмэгдсэн. Тус аймагт 1 үйлдвэрт технологийн шинэчлэл хийж, 3.0 мян.ш/цагт зайрмаг үйлдвэрлэх хүчин чадалтай урсгал шугамыг 2021 онд бүрэн угсарч ашиглалтад оруулснаар хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, 7 нэр төрлийн зайрмаг үйлдвэрлэдэг байсан бол 13 нэр төрөл болгон нэмэгдүүлж, хүнсний үйлдвэрлэлийн "Шилдэг бүтээгдэхүүн"-ээр шалгарлаа. Мөн 3 үйлдвэр цөцгийтэй тараг /0.9 гр чихэртэй, чихэргүй/ үйлдвэрлэж, ЕБС-ийн хүүхдэд сард 2-3 удаа нийлүүлэлт хийж байна. Аарцан бүтээгдэхүүн "Сырок" нэрийн бүтээгдэхүүний шинэ технологийг 2020 онд туршиж, 2021 онд үйлдвэрлэлд нэвтрүүлж, 40.0 мян.ш-ийг үйлдвэрлэж, өмнөх оноос 50 хувиар нэмэгдүүлж, 2023 онд "Импортыг орлох шилдэг бүтээгдэхүүн"-ээр шалгарсан.<br>Гурилын 3 үйлдвэр бүрэн автомат тоног төхөөрөмжтэй, гурилаар бүрэн хангаж, улсын хэмжээний хэрэгцээт гурилын 40-50 хувийг хангах хэмжээний үйлдвэрлэл явуулдаг гурилын үйлдвэрүүд ээлийн хүүгийн хөнгөлөлтөд хамрагдаж, намрын ургац хураалтаас үр тарианы чанараас хамааран жилд 40-90 мян.тн улаанбуудай татан авч байна. Гурилын 2 үйлдвэр чанарын | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | менежментийн стандарт нэвтрүүлж, БНХАУ-руу экспортлох хянан магадлагаанд тэнцсэн ба 2023 онд 1 үйлдвэр 20.0 тн гурил экспортолсон.<br>Талх, нарийн боовны 15 аж ахуйн нэгж, 18 иргэн, хэрчсэн гурилын 2 аж ахуйн нэгж, 8 иргэн үйлдвэрлэл явуулж байна. Хөрөнгийн аргаар үйлдвэрлэх талхны технологи 2 цехээр нэмэгдэж, 4 боллоо. Хүнсний хувьсгалын хүрээнд хөнгөлөлттэй зээлд 3 үйлдвэр хамрагдсанаар үйлдвэрийн байранд урсгал засвар хийж, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг 2 хувиар нэмэгдүүлсэн. Үйлдвэрлэлт суурь оноос 33.7 хувиар нэмэгдсэн.<br>Хаврын улиралд тодорхой хэмжээний махны нөөц бүрдүүлж, нийлүүлэх талаар махны хангамжийг нэмэгдүүлж ажилласан. Мах боловсруулах 3 үйлдвэр, ангилан савлах болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний 1, мал төхөөрөх 2 үйлдвэр, сумдын Засаг дарга нарт мал, махны үнэ хямд үед махны нөөц бүрдүүлэх талаар чиглэл хүргүүлж ажилласан. Мөн махны салбарын малчин, мал мах бэлтгэгч, мал төхөөрөх үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр, махны төрөлжсөн дэлгүүр, хүнсний дэлгүүрийн төлөөлөл, зах худалдааны төв, нийт 21 үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгч нартай "Мал, махны бэлтгэл, махны нөөц бүрдүүлэх" асуудлаар уулзалт хийлээ. Уг уулзалтад 2024 оны хаврын улиралд 140 тонн мах бэлтгэн нийлүүлэх талаар болон 2023.01.01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт /ЗГ-ын тогтоол 2022 оны №224/, 2023.09 сард батлагдсан Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам /ЗГ-ын тогтоол 2023 оны №344/-ыг танилцуулав.<br>Хүнсний хувьсгал хөдөлгөөний хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор арилжааны банкаар дамжуулан 5 жилийн хугацаатай 5 ба 6 хувийн хүүтэй хөрөнгө оруулалтын зээл, 2 жилийн хугацаатай 6 хувийн хүүтэй эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтийг ХХААХҮЯ-д уламжилсан. Үүнээс сүү боловсруулах 1 үйлдвэр 80.0 сая.төг, гурилын 1 үйлдвэр 5.0 тэрбум төг, гурилан бүтээгдэхүүний 3 үйлдвэр 450 сая.төг, махан бүтээгдэхүүний 5 үйлдвэр 1245.0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлэнд хамрагдаж үйл ажиллагаа өргөжүүлэхэд дэмжлэг боллоо.<br><br>**Үр дүн:** 2023 оны гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 2020 онтой харьцуулбал гурил 39.6%, талх, нарийн боов 8.13%, хиамны үйлдвэрлэл 63.5%-аар өссөн байна. 2023 онд 10 үйлдвэрт 6.775 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн. | |
| | **ЗУРГАА. ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | | | | | | | | | | | |
| | **6.1 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | | | | | | |
| | ***6.1.1 Халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.*** | | | | | | | | | | | |
| 172 | ЗГҮАХ-1.1.2.2 АЗДҮАХ-6.1.1.1 | Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийг төсөвт тусгана. | | АЗДТГ, СТСХэлтэс | ОНТ | 0 | 50.0 сая төгрөг батлагдсан | Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах | - | 0.0 | Аймгийн хэмжээнд 2021 оны Короновируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг авахтай холбогдуулан хөрөнгө гаргах 57 асуудлын 599.2 сая төгрөг, 2022 онд 127.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж нийт 726,2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжилт хийсэн. | 100% |
| 173 | ЗГҮАХ-1.1.2.2 АЗДҮАХ-6.1.1.2. | Эмч мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах дадлага болон онолын сургалтыг тасралтгүй зохион байгуулна. | | ЭМГ | ОНТ | 0 | 360 удаагийн сургалт зохион байгуулсан | Эмч мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах дадлага болон онолын сургалтыг тасралтгүй зохион байгуулна. | 3.0 | 0 | Гамшгаас хамгаалах стратегийн команд штабын сургууль болон Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилт хийгдсэн. Үүнд: Нэгдсэн эмнэлэг хээрийн эмнэлэг дэлгэх, Хонгор сумыг нүүлгэн шилжүүлэх, өөгдсөн цагийн байдалд ажиллах зэрэг үйл ажиллагаанууд зохион байгуулагдсан.<br>- Дархан-Уул аймгийн хэмжээнд Томуу, томуу тест өвчний дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, томуугийн харуулдан тандалтын үйл ажиллагааг бэхжүүлэх сайжруулах зорилгын хүрээнд 2023.11.08-09-ний өдрүүдэд | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | "Дархан-Уул аймгийн томуугийн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, зөвлөгөөнд Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол Шинжлэх Ухааны газар, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, Өрх, Сумын эрүүл мэндийн төв зэрэг холбогдох байгууллагуудаас 80 хүн хамрагдсан<br>- Халдварт өвчнөөс сэргийлэх 4 төрлийн сургалтад 90 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан. Мөн улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулахтай холбоотой өрх, сумын ЭМТ-ийн удирдлага, вакцинатори, ЕБС, СӨБ-ын эмч 65 хүнд, "Вакцины хүйтэн хэлхээ, аюулгүй тарилга, халдварын сэргийлэлт хяналт сургалт"-ыг 2 удаа 16 хүнд, ЭМБ-уудын ХСХ-ын үйл ажиллагааг сайжруулах ажлын байран дахь сургалт 175 хүнд, Томуугийн дархлаажуулалтын сургалтыг эрүүл мэндийн 38 ажилтанд зохион байгуулсан нийт 384 хүнд зохион байгуулсан. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл орон нутгийн ТВ-ээр "Тууралтат халдварын тохиолдол, сэргийлэх арга хэмжээ" "Короновируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал", "Дархлаажуулалт гэж юу вэ?", "Улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах тухай" мэдээ, зөвлөмжийг хүргэсэн.<br><br>**Үр дүн:** Сургалтад 384 эмнэлгийн ажилтан, мэдээлэл сурталчилгаанд 4353 хүнд, ТВ-ийн мэдээлэл 6 удаа, цахим мэдээлэл 8 төрлөөр хийсэн байна. | |
| | ***6.1.2 Халдварт цар тахлын голомт, бусад тусламж үйлчилгээнд ажиллах эмч, эмнэлгийн ажилтан, тоног төхөөрөмжийн нөөцийн бэлэн байдлыг хангана*** | | | | | | | | | | | |
| 174 | ЗГҮАХ-1.1.2.2 АЗДҮАХ-6.1.2.1. | Томуугийн вакцин хийх ажлыг эрчимжүүлнэ | | ЭМГ | УТХО | 0 | 90% хамрагдсан | Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд 90% доошгүй хамрагдуулна | 9.0 | | ЭМС-ын 2023.10.10-ны өдрийн А/358, ЭМГ-ын даргын 2023.10.13-ны өдрийн А/120 дугаар тушаалын дагуу 0-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, 65-с дээш насны ахмадууд, архаг хууч өвчтэй нийт 8130 хүнийг томуугийн вакцинаар 100% дархлаажуулсан. Томуугийн вакцинд 2-5 насны 3544 хүүхэд хамрагдсан.<br><br>**Үр дүн:** Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гараагүй. | 100% |
| 175 | ЗГҮАХ-1.1.2.2 АЗДҮАХ-6.1.2.2. | Тархвар Судлалын Заалтаар сургууль, Цэцэрлэгийн хүүхдүүдийг Дархлаажуулалтад хамруулна. | | ЭМГ | - | 0 | 90% хамрагдсан | 90.5 хувийг хамруулна | - | | Тархвар судлалын заалтаар:<br>- ВГВ-ын эсрэг дархлаажуулалтыг төрсний дараа 24 цагийн дотор 1826 хүүхдэд,<br>- Гепатит В вирусын халдвартай эхээс төрсөн 35 нярайд В вирусын эсрэг иммуноглобулиныг 35 хүүхдэд,<br>- Улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтыг 10022 хүүхдэд /10 сартайгаас-8 нас хүртэх/<br>- Томуугийн вакциныг 2-5 насны 3544 хүүхдэд,<br>- Сахуу татрангийн 2 дахь вакцинд 7 нас, 15 настай 3836 хүүхдэд,<br>- Короновируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх дархлаажуулалтад 5-11 нас 565, 12-17 нас 16891, нийт 171371 хүүхэд 1-4-р тун хийлгэсэн.<br>**Үр дүн:** Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гараагүй. | 100% |
| 176 | ЗГҮАХ-1.1.2.2 АЗДҮАХ-6.1.2.3 | Халдварт өвчнөөс сэргийлэх хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг хангана. | | ЭМГ | УТХО | 0 | 14 Төрлийн 59 тоног төхөөрөмжтэй | Тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ | 20.0 | | Халдварт өвчнөөс сэргийлэх хяналтын албанд багаж материал ариутгадаг автоклавын аппарат 1 ширхэг, өрөөний нян бактер устгадаг зөөврийн кварц 1 ширхэгийг авсан.<br>Үр дүн: Нэгдсэн эмнэлэгт халдвараас сэргийлэх 2 тоног төхөөрөмж нэмэгдсэн. | 100% |
| 177 | ЗГҮАХ-1.1.2.2 АЗДҮАХ-6.1.2.4 | Халдварт өвчнөөс сэргийлэх мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаагаар зохион байгуулна. | | ЭМГ | УТХО | 0 | 17000 иргэн хамрагдсан. | 20000иргэн хамруулна. | 2.0 | | Амьсгалын замын халдвар, ТТӨ-өөс сэргийлэх–хандалт 12038 иргэн<br>- Дархлаажуулалт гэж юу вэ? сэдэвт мэдээллийг 9200 иргэнд<br>- Улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах тухай – хандалт 2578 байна.<br>- ТТӨ-ий өнөөгийн нөхцөл байдал, сэргийлэх арга хэмжээ – хандалт 537<br><br>**Үр дүн:** Сургалт, мэдээллийг 24353 хүнд, ТВ-ийн мэдээлэл 6 удаа, цахим мэдээлэл 8 төрлөөр хийсэн байна. | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 178 | ЗГҮАХ-1.1.2.2 АЗДҮАХ-6.1.2.5 | Цар тахлын үед ажиллах хүний нөөц болон эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг 100% хангана. | | Эрүүл мэндийн газар | УТХО | 0 | Хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | Тоног төхөөрөмжийг сайжруулна | 50.0 | | Цар тахлын үед ажиллах хүний нөөц батлагдсан орон тоогоор ажиллаж байна.<br>Цар тахал, томуугийн дэгдэлт үүссэн үед нэмэлтээр ажилуулах хүний нөөцийн төлөвлөлт хийсэн ба эм тарианы 2 сарын нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>Халдвараас сэргийлэх чиглэлээр Ходоодны дуран угаагчийн шүүлтүүр, шүдний аппаратны шүүлтүүр, Гемодиализын аппаратны шүүлтүүр, ариутгалын кварцын аппаратны лампнууд, Амьсгалын аппаратны сенсор, Биохими болон гемотлогийн аппаратны ламп зүү, Автоклавын шүүлтүүр, масло, Отосс шүүлтүүр гэх мэт хугацаат сэлбэг хэрэгслүүдийг цаг тухай бүрт сольж эвдрэл гэмтэл гарсан үед цаг алдалгүй засварласан.<br>**Үр дүн:** 10 тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийг авч эвдрэл гэмтэл гарсан үед цаг алдалгүй засварлан үйлчилгээг шуурхай хүргэлээ. | 100% |

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

ХБТХОХ-ИЙН ДАРГА П.БАТСҮХ

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭЖ, БОЛОВСРУУЛСАН

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГЧ Б.БАТСҮХ

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙГ 2023 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА /арга хэмжээгээр/

2023.11.24 Дархан-Уул аймаг

| № | Хяналтад авсан бодлого / Арга хэмжээний үнэлгээ | | | Бүгд | Бодлого, арга хэмжээгээр | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | I. Хүний хөгжлийн бодлого | II. Эдийн засгийн бодлого | III. Засаглалын бодлого | IV. Ногоон хөгжлийн бодлого | V. Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого | VI. Цар тахлын хүндрэлийг даван туулах бодлого |
| 1. | Хяналтанд авсан нийт зорилтын тоо | | | **42** | **6** | **7** | **4** | **2** | **1** | **1** |
| 2. | Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо | | | **177** | **51** | **62** | **26** | **23** | **8** | **7** |
| 3. | Үнээс | Үр дүнтэй буюу 100.0% | | **134** | 38 | 42 | 22 | 19 | 6 | 7 |
| | | Тодорхой үр дүнд хүрсэн буюу | 90.0% | **18** | 4 | 11 | 1 | 1 | 1 | - |
| | | | 70.0% | **16** | 8 | 5 | 2 | 1 | - | - |
| | | Эрчимжүүлэх шаардлагатай буюу | 50.0% | **1** | 1 | - | - | - | - | - |
| | | | 30.0% | **3** | - | 2 | - | 1 | - | - |
| | | Үр дүнгүй буюу 0.0% | | **5** | - | 2 | 1 | 1 | 1 | - |
| **Хэрэгжилтийн дундаж хувь, оноо** | | | | **92.0% буюу 4.60 оноо** | **93.53% буюу 4.67 оноо** | **90.32% буюу 4.50 оноо** | **93.46% буюу 4.67 оноо** | **90.87% буюу 4.54 оноо** | **86.25% буюу 4.31 оноо** | **100% буюу 5.0 оноо** |

Тайлбар: Эрх зүйн акт батлагдаагүй тул 18 дугаар арга хэмжээг үнэлгээнээс хасаж тооцлоо.

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙГ 2023 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2023.12.15

### Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

"Дархан-Уул аймгийг 2023 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

### Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй

Засгийн газрын 2021 оны 374 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн "Дархан-Уул аймгийг 2023 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт"-ийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар, зорилтын хэрэгжилтийг энэ журмын 6.2.3-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр 4 ангилалд шилжүүлэн тооцлоо.

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нарын 2023 оны 11 сарын 13-ны өдрийн хуралдаан, 11 сарын 17-ны өдрийн аймгийн ИТХ-ын зөвлөлийн хуралдааг, 11 сарын 24-ний өдрийн аймгийн ИТХ-ын хуралдаанаас гарсан санал, зөвлөмж, аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс тус тайлангийн 19 арга хэмжээний хэрэгжилтэд сайжруулалт хийсэн тайланд үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 удаа гүйцэтгэлээ.

### Гурав. Дүгнэлт

"Дархан-Уул аймгийг 2023 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний
Нэг. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд 52 арга хэмжээ,
Хоёр. Эдийн засгийн бодлогын хүрээнд 62 арга хэмжээ,
Гурав. Засаглалын бодлогын хүрээнд 26 арга хэмжээ,
Дөрөв. Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 23 арга хэмжээ,
Тав. Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд 8 арга хэмжээ,
Зургаа. Цар тахлын хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд 7 арга хэмжээ, нийт 6 бодлогын хүрээнд **178** арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд

ерөнхий үнэлгээ арга хэмжээгээр **“Тодорхой үр дүнд хүрсэн”** буюу **92.0%**-иар үнэлэгдлээ.

- “Үр дүнтэй” буюу 100% үнэлгээтэй 134 арга хэмжээ,
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90-70% үнэлгээтэй 34 арга хэмжээ,
- “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-50% үнэлгээтэй 4 арга хэмжээ байна.

*Журмын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу* ***арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар илэрхийлбэл:***

| № | Хяналтад авсан бодлого / Арга хэмжээний үнэлгээ | | | Бүгд | Бодлого, арга хэмжээгээр | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | I. Хүний хөгжлийн бодлого | II. Эдийн засгийн бодлого | III. Засаглалын бодлого | IV. Ногоон хөгжлийн бодлого | V. Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого | VI. Цар тахлын хүндрэлийг даван туулах бодлого |
| 1. | Хяналтанд авсан нийт зорилтын тоо | | | **42** | **6** | **7** | **4** | **2** | **1** | **1** |
| 2. | Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо | | | **177** | **51** | **62** | **26** | **23** | **8** | **7** |
| 3. | Үнээс | Үр дүнтэй буюу 100.0% | | **134** | 38 | 42 | 22 | 19 | 6 | 7 |
| | | Тодорхой үр дүнд хүрсэн буюу | 90.0% | **18** | 4 | 11 | 1 | 1 | 1 | - |
| | | | 70.0% | **16** | 8 | 5 | 2 | 1 | - | - |
| | | Эрчимжүүлэх шаардлагатай буюу | 50.0% | **1** | 1 | - | - | - | - | - |
| | | | 30.0% | **3** | - | 2 | - | 1 | - | - |
| | | Үр дүнгүй буюу 0.0% | | **5** | - | 2 | 1 | 1 | 1 | - |
| **Хэрэгжилтийн дундаж хувь, оноо** | | | | **92.0% буюу 4.60 оноо** | **93.53% буюу 4.67 оноо** | **90.32% буюу 4.50 оноо** | **93.46% буюу 4.67 оноо** | **90.87% буюу 4.54 оноо** | **86.25% буюу 4.31 оноо** | **100% буюу 5.0 оноо** |

Тайлбар: Эрх зүйн акт батлагдаагүй тул 18 дугаар арга хэмжээг үнэлгээнээс хасаж тооцлоо.

## **0-50%-ийн үнэлгээтэй 9** арга хэмжээнүүдийг дэлгэрэнгүй танилцуулбал:

| № | Бодлогын үндэслэл | Зорилт, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч | Эх үүсвэр | Суурь түвшин | Хүрэх түвшин | Зарцуулсан төсөв | Хүрсэн түвшин | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 42 | МУХТЖ ҮЧ--9.1.1, АХҮЧ-3.4.4 АЗДҮАХ -1.5.7.2 | Залуучуудын хөгжлийн төвд Америкийн соёл мэдээллийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна. | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | Нийт залуучуудын 45 хувьд үйлчилгээ үзүүлсэн. | 50% | 4.0 | Хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан 16 төрлийн 90 удаагийн хөтөлбөрийг зохион байгуулсан.<br>Англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих зорилготойгоор "Call for you" хөтөлбөрт 120 өсвөр үеийн залуучууд бүртгүүлснээс 3-н шатны шалгаруулалтаар 25 хүнийг сонгон англи хэлний мэдлэг болон хувь хүний хөгжлийг дээшлүүлэв.<br>Дархан-Уул аймгийн Засаг даргын ивээл дор Junior Empower Program хөтөлбөрт нийт 90 сурагч бүртгүүлж, сонгон шалгаруулалтаар 15 сурагч сонгогдож хувь хүний хөгжил, гадаадад суралцах талаарх мэдлэг болон сайн дурын ажил хийх талаар мэдлэгээ нэмэгдүүлэв.<br>**Үр дүн:** SIP-2 хөтөлбөрийг хэрэгжүүлж 8 дадлагажигч, 5 төгсөгч нийт 15 өсвөр үеийн залуучуудыг 6 сарын хугацаатай ажиллуулж байна. | 50% |
| | | | | | | | | Дархан төмөрлөгийн үйлдвэр нь | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 65 | МУХТ ЖҮЧ-4.2.11, ШСБ ЗГҮАХ 3.2.7, 3.2.8 АХҮЧ-4.1.1, 4.1.7, ЗДҮАХ 2.2.1.3 | Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах барилгын явц, хувиар | "Дархан Төмөрлөг ийн үйлдвэр" ТӨХК | - | Хаягдал төмрөөр эсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. | Үйлдвэрийн өргөтгөлийн ажил эхэлсэн байна. | - | менежментийн гэрээгээр ажиллах хугацаанд хүчин чадлын 20 хувийг ашиглаж байсан. Засгийн газрын шийдвэрээр 2022 онд "Дархан Төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК болсон. 2021 онд "Монгол Ган цогцолбор I" төслийн ТЭЗҮ боловсруулагдаж дууссан. Хонгор сумын Төмөртолгойн уурхай, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Төмөртэйн уурхайг түшиглэн "Монгол Ган цогцолбор 1" төслийг хэрэгжүүлэхэд үйлдвэрийн барилгын ажлын өргөтгөлд шаардагдах 24 га газрын асуудлыг шийдвэрлэсэн.<br>2023 онд Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэр төслийн гадна цахилгаан хангамжийн ТЭЗҮ, зураг төслийн ажлын санхүүжилтийг улсын төсөвт суулгахаар саналаа явуулсан. Төмөртэйн уурхайн нөөцийн нарийвчилсан хайгуулын ажлыг хийлгэж нөөцийг шинэчлэн баталгаажуулахаар ажиллаж байна.<br>**Үр дүн:** "Монгол ган цогцолбор 1" төсөл хэрэгжүүлснээр нэмүү өртөг шингэсэн, импортыг орлох эцсийн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1915 шууд ажлын байр шинээр бий болно. Бусад төрлийн үйлдвэрлэл кластер хэлбэрээр хөгжих нөхцөл бүрдэнэ. Барилгын өртөг зардал, барилгын материалын үнэ тогтворжуулахад хувь нэмрийг оруулна. | 30% |
| 98 | | Төв авто зам-Төмөр замын гарам хүртэлх авто замын шинэчлэлт /Дархан сум 1, 5-р баг/ | АЗДТГ | УТХО | Хатуу хучилттай 1.091км авто замтай | 1.091км авто замыг өргөтгөж, шинэчилнэ | 2,557.8 | Төв авто зам-Төмөр замын гарам хүртэлх авто зам, явган замын засвар шинэчлэлтийн ажлыг 2,5 тэрбум төгрөгөөр ажил 0 хувийн гүйцэтгэлтэй байна. Цахимбар инженеринг ХХК гэрээ байгуулсан. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тус төслийн дутуу санхүүжилт болох 2024 онд 253.6 сая төгрөгийг баталсан. Дархан сумын 1,8-р багийг холбосон гүүрэн гарц ашиглалтад ороогүй тул Төв авто зам-Төмөр замын гарам хүртэлх авто замын шинэчлэлтийн ажлыг эхлүүлэх боломжгүй болсон. Тус ажлыг 2024 оны II улирал бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөөд байна. | 0% |
| 104 | ЗГҮАХ-3.7.1, АХҮЧ-4.3.1, 4.3.2, 4.3.3 АЗДҮАХ-2.7.1.2. | Орхон, Хонгор сумдын төвийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангуулна. | Аймаг, сумдын ЗДТГ | ОНХСан | Сумдын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжих хугацаа дууссан. | Хонгор сумын ерөнхий төлөвлөгөө шинэчлэгдсэн байна. | 65.0 | -Орхон сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийхээр зураг төслийн ажлын даалгавар боловсруулан ГЗБГЗЗГ-тай зөвшилцөн аймгийн Засаг даргаар 2023 оны 04 сарын 23-ны өдөр батлуулж, Орхон сумын ЗДТГ-т хүргүүлсэн. Орхон сумын ОНХС-аас 50 сая төгрөг батлагдаж 3 удаа тендер сонгон шалгаруулалт зарласан ч оролцогч байхгүй байна. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2024 онд 100 сая төгрөгөөр төсөвт суулгах асуудлаар сумын ИТХ-ын 2024.12.07 өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.<br>-Хонгор сумын 327.5 мянган га талбайд 170 сая төгрөгийн өртгөөр "Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажлын даалгаварыг боловсруулж тендер зарлан "Тэгш хэм" ХХК шалгарсан. Тухайн компани ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг гүйцэтгэж чадахгүй болсноо мэдэгдэж албан тоот ирүүлсний дагуу гэрээ цуцлагдсан. Дахин тендер зарлагдсан. | 30% |
| 105 | ЗГҮАХ-3.7.1, АХҮЧ-4.3.1, 4.3.2, 4.3.3 АЗДҮАХ-2.7.1.3. | Дархан сумын 7, 14, 29, 30 дугаар хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна. | АЗДТГ | УТХО, ОНТ | 4 хорооллын хэсэгчилсэн ~~ерөнхий~~ төлөвлөгөөгүй. | 14 дүгээр хорооллын хэсэгчилсэн ~~ерөнхий~~ төлөвлөгөөтэй болсон байна. | 36.3 | Дархан сумын 12 дугаар баг, 7, 14 дүгээр хороолол, 15 дугаар багт байрлах 29, 30 дугаар хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан.<br>Дархан сумын 13-р багт Залуус-1 хороолол 102 га талбайд, 15-р багт Залуус-2 хороололд 23 га талбайд хорооллуудыг төлөвлөн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Инженер геодези ХХК гүйцэтгэж, аймгийн ИТХ-ын 2023.02.10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Дархан сумын 12 баг, 14-р хорооллын газар эзэмшигч нарыг зохион байгуулалтад оруулж 110 айлыг "Идиал групп" ХХК-тай гэрээ байгуулан хэсэгчилсэн ерөнхий | 0% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төлөвлөгөөний зураг төслийн ажлыг 2021 онд эхлүүлсэн. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байна.<br>Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад 2023 онд тусгагдсан 750 сая төгрөгийн санхүүжилттэй Дархан сумын 1, 3, 5, 6, 7, 8, 9, 14, 15 дугаар багийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг хийх тендер Төрийн худалдан авах ажиллагааны газраар зарлагдан одоогоор гүйцэтгэгч тодроогүй байна. Энэхүү ажил хийгдсэнээр Дархан сумын нутаг дэвсгэрт дахин төлөвлөлтийн 9-н байршилд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө бүрэн хийгдэж дуусах болно.<br>**Үр дүн:** Залуус 1,2 төслийн хүрээнд 127 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдсан. Дэд бүтэц татах эхний үе шатны ажлыг 47.0 тэрбум төгрөг, 2 үе шатны ажлыг 2024-2025 онд 30.0 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлнэ | |
| 131 | "Алсын хараа-2050" зорилт 7.3, 1 үе шат 2021-2030 АХҮЧ-7.1.6 АЗДҮАХ-3.3.1.4. | Дархан сумын эргэн тойронд аянга зайлуулах хамгаалалтын системийн тоог жилд нэгээр нэмж байгуулна. | Онцгой байдлын газар | ОНТ | Дархан сумын 9, 15 дугаар багийн нутаг дэвсгэрт 2 ширхэг босоо аянга хүлээн авагч суурилуулсан | 1-ээс доошгүй аянга зайлуулагч шинээр нэмэгдүүлнэ. | 15.0 | Дархан сумын эргэн тойронд аянга зайлуулах хамгаалалтын систем нь 2019 онд 9, 15-р багт хийгдсэн байна. 2021-2023 онд дахин аянга зайлуулах хамгаалалтын системийн хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй тул хийгдээгүй. | 0% |
| 160 | ЗГҮАХ 6.1.9.2 АЗДҮАХ-4.2.2. | Гэр хорооллын айл өрхийн хог татан авах, үнс хадгалах зориулалтын 2000 савыг гэр хорооллын айл өрхүүдэд үе шаттайгаар нийлүүлнэ. | Захирагчийн ажлын алба, НААҮГ | ОНТ | 100 ш үнсний савыг Дархан сумын 2 багт нийлүүлсэн | Үнсний савыг гэр хорооллын 600 айлд нийлүүлнэ. | 30.0 | 2021 онд гэр хорооллын айл өрхийн хогийг татан авах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 130.0 сая.төг-ийн хөрөнгө оруулалтаар 18 м3 багтаамжтай Хово маркийн авто машин, 2022 онд 8 ш техникээр парк шинэчлэлтийг нэмэгдүүлэх ажилд 1927.0 сая.төг, 2023 онд иргэдийн хог хаягдлын боловсролыг дээшлүүлж, хотын өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар /19.6 сая.төг/ 95 ш хуванцар савыг бэлэн болгож, нийтийн эзэмшлийн зам талбайд байршуулсан.<br>**Үр дүн:** Гэр хорооллын айл өрхийн хог хаягдлын татан авалт сайжирч, орон сууцны иргэд хуванцар саванд хогоо ангилдаг болсон. | 0% |
| 161 | АХҮЧ-3.3.2 АЗДҮАХ-4.2.3.3 | Гэр хорооллын айл өрхүүдийн яндангийн тооллого хийж, төвлөрсөн дэд бүтцэд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | АЗДТГ-ын ХБТХОХ | ОНТ | Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн ажлыг 2017-2020 онд 3 удаа зохион байгуулсан. | Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн дэд бүтцэд холбох ажлыг хийнэ. | 20.0 | Аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг I улиралд хийж дата мэдээг "Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан" www.envpol.mne.gov.mn-д байршуулсан.<br>Үр дүн:<br>1.Аймгийн хэмжээнд галлагаатай 7513 өрх тоологдож өмнөх оноос 356 айл буюу 4.7%-аар нэмэгдсэн.<br>2.15-100кВт хүртэл хүчин чадалтай 34 зуух 1105.0 тн нүүрс шатааж өмнөх оноос зуух 1-ээр, түлш 0.8%-аар нэмэгдсэн байна.<br>3.100-4200 кВт хүртэл хүчин чадалтай 18 зуух 10533 тн нүүрс шатаасныг өмнөх оны дүнтэй харьцуулахад зуухны тоо нэмэгдээгүй шатаасан нүүрсний хэмжээ 2.9%-иар багассан байна.<br>4. 4200 кВт-аас дээш хүчин чадалтай ДДЦСтанц ТӨХК, Дулаан Шарын гол ТӨХК-уудын 13 зуух 453312 тн нүүрс шатаасан нь өмнөх оноос Дулаан Шарын гол ТӨХК 260 тн, ДДЦСтанц ТӨХК 94639 тн-оор нэмэгдсэн.<br>21255 тээврийн хэрэгсэл тоологдсон бөгөөд өмнөх оноос 8.9%-иар нэмэгдсэн.<br>2024 оны 1 дүгээр улиралд багтаан агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаад байна.<br>**Үр дүн:** Агаарын бохирдлыг бууруулах нөхцөл боломж бүрдэж байна. | 30% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 168 | ЗГҮАХ-6.2.13, АХҮЧ-4.1.3 АЗДҮАХ-5.1.3.1 | Дархан үйлдвэр технологийн парк"-ийн ТЭЗҮ боловсруулж, ҮТП-ын 1, 2 дугаар бүсэд үйлдвэрлэлийг кластер хэлбэрээр хөгжүүлнэ. | "Дархан үйлдвэр технологийн парк" ОНӨААТҮГ, ХБТХОХ | ОНТ | Дархан Үйлдвэрлэл Технологийн Парк ОНӨААТҮГ нь ТЭЗҮ болон холбогдох бичиг баримтууд одоо хүчин төгөлдөр байгаа тусгай зөвшөөрлийн хугацаа 2022 онд дуусгавар болно. | ТЭЗҮ-ийг боловсруулж, аймгийн ИТХ-ийн хуралдаанаар батлуулна. | 220.0 | Дархан Үйлдвэрлэл Технологийн Парк ОНӨААТҮГ нь ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар боловсруулагдсан. ТЭЗҮ боловсруулахад шаардагдах 220.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй | 0% |

Дээрх 9 арга хэмжээний хувьд:

- Санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй 65,131,168 дугаар арга хэмжээнүүд; хугацааны хувьд хэрэгжих боломжгүй 98, 104, 105, 161 дүгээр арга хэмжээнүүд нийт 7 арга хэмжээ нь 2022 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээ нэмэгдэх боломжгүй байна. 2024 онд хэрэгжих боломжтой 98, 104,105 дугаар арга хэмжээнүүд байна.
- 42, 160 дугаар арга хэмжээнүүдийн хувьд хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнаагүй байна.

### *Дөрөв. Цаашид анхаарах асуудал (Зөвлөмж)*

Сайн тал:

2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилттэй харьцуулахад сайжруулах арга хэмжээний тоо 3 дахин буурсан ( 2022 онд 60 байсан бол 2023 онд 19), хэрэгжилтийг хугацаанд нь ирүүлсэн, суурь түвшин, шалгуур үзүүлэлтийг тусгасан. Хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнасан байна. Зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэхэд ахицтай хандсан. Хийсэн ажлын үр дүнг 2000 тэмдэгтэд багтаан хэмжиж болохуйцаар тайлагнасан байна.

Дутагдалтай тал:

Санхүүжилт нь шийдэгдсэн, сонгон шалгаруулалтын хугацаа шаардагдсан, орон нутгийн хөгжил болон иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлэхүйц Дугаар 98, 104, 105 арга хэмжээнүүдийг 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН